# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ, ҮР ДҮНГИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2023.04.05

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг (Ковид-19) болон бусад халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого, Хүний хөгжлийн бодлого, Эдийн засгийн бодлого, Засаглалын бодлого, Ногоон хөгжил гэсэн **5** бүлгийн **169** зорилттойгоор боловсруулан, батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийт 169 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 112 зорилт 100 хувь, 16 зорилт 90 хувь, 21 зорилт 70 хувь, 11 зорилт 50 хувь, 7 зорилт 30 хувь, 2 зорилт 0 хувь буюу дунджаар **91.5 хувийн** гүйцэтгэлтэй байна гэж үнэллээ.

Үүнд:

- (Ковид-19) болон бусад халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого” 92.7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Хүний хөгжлийн бодлого” 86.6 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Эдийн засгийн бодлого” 84.3 буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Засаглалын бодлого” 93.8 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн”
- “Ногоон хөгжил” бүлэг 100 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” тус тус үнэлгээтэй байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг 2022 оны жилийн эцсийн байдлаар салбар бүрээр нь товч танилцуулбал:

**Нэг. “Ковид-19 болон бусад халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого”** 11 зорилттой.

Үүнээс: 9 зорилт 100 хувь, 1 зорилт 90 хувь, 1 зорилт 30 хувийн биелэлттэй байна.

**30 хувийн биелэлттэй зорилтоос дурьдвал:**

- Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн өрх, иргэдэд үзүүлэх халамж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

Бүлгийн **нийт** зорилтын хэрэгжилт **92.72** хувь байна.

**Хоёр. Хүний хөгжлийн бодлого:**

Хүний хөгжил бүлэг 6 дэд бүлгийн 63 зорилттой.

Үүнээс: 35 зорилт нь 100 хувь, 9 зорилт нь 90 хувь, 9 зорилт 70 хувь, 8 зорилт 50 хувь, 1 зорилт 30 хувь, 1 зорилт 0 хувийн биелэлттэй байна. Үүнээс:

**2.1** _Эрүүл мэнд_ дэд бүлэг нь 14 зорилтоос 4 зорилт нь 100 хувь, 3 зорилт нь 90 хувь, 2 зорилт 70 хувь, 2 зорилт нь 50 хувь, 1 зорилт нь 30 хувь буюу дунджаар **80.7** хувь

**30 хувийн биелэлттэй зорилтоос дурьдвал:**

- “Хачигт халдварын оношилгооны загвар төв”-ийг байгуулж, Сүрьеэгийн эмнэлгийг бие даасан байртай болгох

**2.2** _Боловсрол_ дэд бүлэг нь 11 зорилтоос 4 зорилт нь 100 хувь, 3 зорилт нь 90 хувь, 2 зорилт 70 хувь, 2 зорилт нь 50 хувь буюу дунджаар **82.7** хувь;

**2.3** _Биеийн тамир, спорт_ дэд бүлэг нь 12 зорилтоос 7 зорилт нь 100 хувь зорилт нь 90 хувь, 2 зорилт 70 хувь, 2 зорилт нь 50 хувь буюу дунджаар **85.8** хувь;

**2.4** _Соёл, урлагийн бодлого_ дэд бүлэг нь 9 зорилтоос 4 зорилт нь 100 хувь, 2 зорилт нь 90 хувь, 2 зорилт 70 хувь, 1 зорилт нь 50 хувь буюу дунджаар **85.5** хувь;

**2.5** _Хүүхэд, залуучууд, гэр бүл_ дэд бүлэг нь 7 зорилтоос 6 зорилт нь 100 хувь, 1 зорилт 70 хувь буюу дунджаар **95.7** хувь;

**2.6** _Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал_ дэд бүлэг нь 10 зорилтоос 7 зорилт нь 100 хувь, 1 зорилт нь 90 хувь, 1 зорилт 70 хувь, 1 зорилт 0 хувь буюу дунджаар **86.0** хувь;

**0 хувийн биелэлттэй зорилтоос дурьдвал:**

-Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

Бүлгийн **нийт** зорилтын хэрэгжилт **86.6** хувийн биелэлттэй байна.

**Гурав. Эдийн засгийн бодлого:**

**Эдийн засгийн бодлого** бүлэг нь 6 дэд бүлгийн 63 зорилттой.

Үүнээс: 42 зорилт нь 100 хувь, 4 зорилт нь 90 хувь, 9 зорилт 70 хувь, 2 зорилт 50 хувь, 1 зорилт 50 хувь, 1 зорилт нь 30 хувийн биелэлттэй.

**3.1** _Хөдөө аж ахуйн бодлого_ дэд бүлэг нь 12 зорилтоос 9 зорилт нь 100 хувь, 1 зорилт 70 хувь, 1 зорилт нь 50 хувь, 1 зорилт 30 хувь буюу дунджаар **87.5** хувь;

**_30 хувийн биелэлттэй зорилтоос дурьдвал:_**

- "Мал эмнэлгийн ариутгал, халдваргүйтгэл, хяналт шалгалтын нэгдсэн цэг”-ийг Тахилт, Хөшөөтийн даваанд байгуулах

**3.2** _Байгаль орчин_ дэд бүлэг 9 зорилтоос 7 зорилт нь 100 хувь, 2 зорилт 70 хувь буюу дунджаар **93.33** хувь;

**_30 хувийн биелэлттэй зорилтоос дурьдвал:_**

- Олон улсын жишигт нийцсэн аялал жуулчлалын олон талт арга хэмжээг /эвент/ бий болгож, дотоод, гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

**3.3** _Аялал жуулчлал_ дэд бүлэг нь 5 зорилтоос 2 зорилт нь 100 хувь, 2 зорилт 70 хувь, 1 зорилт нь 30 хувь буюу дунджаар **74.0** хувь;

***30 хувийн биелэлттэй зорилтоос дурьдвал:***

- Олон улсын жишигт нийцсэн аялал жуулчлалын олон талт арга хэмжээг /эвент/ бий болгож, дотоод, гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

**3.4** *Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ* дэд бүлэг нь 9 зорилтоос 6 зорилт нь 100 хувь, 1 зорилт 70 хувь, 1 зорилт нь 30 хувь, 1 зорилт нь 0 хувь буюу дунджаар **77.7** хувь;

***30 хувийн биелэлттэй зорилтоос дурьдвал:***

- Орон нутгийн түүхий эдэд түшиглэн Хушаат суманд "Цардуулын үйлдвэр байгуулна"

***0 хувийн биелэлттэй зорилтоос дурьдвал:***

- Стандартын хэрэгжилтийг сайжруулж, хэмжил зүйн зөрчлөөс сэргийлэх зорилгоор эталоны нарийвчлалыг дээшлүүлэн, цахилгаан эрчим хүчний 3 фазын тоолуур шалгах суурин эталон төхөөрөмжийг суурилуулж, хэмжлийн нэгдмэл байдлыг хангана.

**3.5** *Хөрөнгө оруулалт, дэд бүтэц* дэд бүлэг нь 20 зорилтоос 12 зорилт нь 100 хувь, 4 зорилт 90 хувь, 3 зорилт нь 70 хувь, 1 зорилт нь 50 хувь буюу дунджаар **91.0** хувь;

**3.6** *Санхүү, төсвийн зохицуулалт* дэд бүлэг нь 8 зорилтоос 6 зорилт нь 100 хувь, 2 зорилт 30 хувь буюу дунджаар **82.5** хувь;

***30 хувийн биелэлттэй зорилтоос дурьдвал:***

- Инновацийн үйл ажиллагааг дагнан эрхлэх орон нутгийн өмчит хуулийн этгээдийг шинээр байгуулж, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.

- Аймгийн төвд Монгол банкны салбарыг нээж, арилжааны банкуудын үйл ажиллагааг чадавхжуулна.

Бүлгийн **нийт** зорилтын хэрэгжилт **84.3** хувь байна

## Дөрөв. Засаглалын бодлого:

Засаглалын бодлого бүлэг нь 3 дэд бүлгийн 26 зорилттой.

Үүнээс: 20 зорилт нь 100 хувь, 2 зорилт нь 90 хувь, 3 зорилт 70 хувь, 1 зорилт 50 хувийн биелэлттэй байна.

**4.1** *Нутгийн захиргаа* дэд бүлэг нь 13 зорилтоос 9 зорилт нь 100 хувь, 2 зорилт нь 90 хувь, 1 зорилт 70 хувь, 1 зорилт 50 хувь буюу дунджаар **92.3** хувь;

**4.2** *Хууль, эрх зүй* дэд бүлэг нь 9 зорилтоос 8 зорилт нь 100 хувь, 1 зорилт 70 хувь, буюу дунджаар **96.6** хувь;

**4.3** *Батлан хамгаалах* дэд бүлэг нь 4 зорилтоос 3 зорилт нь 100 хувь, 1 зорилт 70 хувь буюу дунджаар **92.5** хувь;

Бүлгийн **нийт** зорилтын хэрэгжилт **93.8** хувь байна.

**Тав. Ногоон хөгжил бодлого:**

Ногоон хөгжил бүлэг нь 6 зорилттой.
Үүнээс: 6 зорилт нь 100 хувийн биелэлттэй байна.
Бүлгийн **нийт** зорилтын хэрэгжилт **100** хувь байна.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮНГИЙН НЭГТГЭЛ**

**/2022 оны жилийн эцсийн байдлаар/**

| | Агуулга | Нийт зорилтын тоо | Үүнээс | | | | | | Нийт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | |
| **Нэг** | **(КОВИД-19) БОЛОН БУСАД ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО** | **11** | **9** | **1** | **-** | **-** | **1** | **-** | **92.7** |
| 1.1 | (Ковид-19) болон бусад халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлого, шинэчлэлийн хүрээнд: | 11 | 9 | 1 | - | - | 1 | - | **92.7** |
| **Хоёр** | **ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | **63** | **35** | **9** | **9** | **8** | **1** | **1** | **86.6** |
| 2.1 | Эрүүл мэндийн бодлого, шинэчлэлийн хүрээнд: | 14 | 7 | 2 | 1 | 3 | 1 | - | **80.7** |
| 2.2 | Боловсролын бодлого, шинэчлэлийн хүрээнд: | 11 | 4 | 3 | 2 | 2 | - | - | **82.7** |
| 2.3 | Биеийн тамир, спортын бодлого, шинэчлэлийн хүрээнд: | 12 | 7 | 1 | 2 | 2 | - | - | **85.8** |
| 2.4 | Соёл, урлагийн бодлого, шинэчлэлийн хүрээнд: | 9 | 4 | 2 | 2 | 1 | - | - | **85.5** |
| 2.5 | Хүүхэд, залуучууд, гэр бүлийн бодлого, шинэчлэлийн хүрээнд: | 7 | 6 | - | 1 | - | - | - | **95.7** |
| 2.6 | Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгалын бодлого, шинэчлэлийн хүрээнд: | 10 | 7 | 1 | 1 | - | - | 1 | **86.0** |
| **Гурав** | **ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | **63** | **42** | **4** | **9** | **2** | **5** | **1** | **84.3** |
| 3.1 | Хөдөө аж ахуйн бодлого, шинэчлэлийн хүрээнд | 12 | 9 | - | 1 | 1 | 1 | - | **87.5** |
| 3.2 | Байгаль орчин бодлого, шинэчлэлийн хүрээнд: | 9 | 7 | - | 2 | - | - | - | **93.3** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | Аялал жуулчлал бодлого, шинэчлэлийн хүрээнд: | 5 | 2 | - | 2 | - | 1 | - | **74.0** |
| 3.4 | Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ бодлого, шинэчлэлийн хүрээнд: | 9 | 6 | - | 1 | - | 1 | 1 | **77.7** |
| 3.5 | Хөрөнгө оруулалт, дэд бүтэц бодлого, шинэчлэлийн хүрээнд: | 20 | 12 | 4 | 3 | 1 | - | - | **91.0** |
| 3.6 | Санхүү, төсвийн зохицуулалт бодлого, шинэчлэлийн хүрээнд: | 8 | 6 | - | - | - | 2 | - | **82.5** |
| **Дөрөв** | **ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | **26** | **20** | **2** | **3** | **1** | **-** | **-** | **93.8** |
| 4.1 | Нутгийн захиргаа бодлого, шинэчлэлийн хүрээнд | 13 | 9 | 2 | 1 | 1 | - | - | **92.3** |
| 4.2 | Хууль, эрх зүй бодлого, шинэчлэлийн хүрээнд | 9 | 8 | - | 1 | - | - | - | **96.6** |
| 4.3 | Батлан хамгаалах бодлого, шинэчлэлийн хүрээнд | 4 | 3 | - | 1 | - | - | - | **92.5** |
| **Тав** | **НОГООН ХӨГЖИЛ** | **6** | **6** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **100** |
| 5.1 | Ногоон хөгжил бодлого, шинэчлэлийн хүрээнд: | 6 | 6 | - | - | - | - | - | **100** |
| Нийт | | **169** | **112** | **16** | **21** | **11** | **7** | **2** | **91.5** |

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ
## /2022 оны жилийн эцсийн байдлаар/

| Д/д | | Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэл (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Он | Түвшин | | | |
| **НЭГ.(КОВИД-19) БОЛОН БУСАД ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО** | | | | | | | | | |
| 1 | 1.1 | (Ковид-19) болон халдварт цар тахлын үед эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн бэлэн байдлыг хангаж, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ. | Улс, аймгийн төсөв | (Ковид-19) болон халдварт цар тахлын үед ажиллах эмч мэргэжилтнүүд, зохион байгуулсан сургалт | 2021 | (Ковид-19 болон халдварт цар тахал)-ын үед ажилласан эмч мэргэжилтнүүд-1265, 152 удаагийн сургалт зохион байгуулан бэлэн байдлыг хангасан | "Ковид-19" болон халдварт цар тахлын үед ажиллах эмч мэргэжилтнүүд-1263, 100 удаагийн сургалт зохион байгуулан бэлэн байдлыг хангана. | "Ковид-19" болон бусад халдварт цар тахлын үед эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн бэлэн байдлыг хангах зорилгоор дайчлагдан ажиллах боломжтой эрүүл мэндийн байгууллагаас тэтгэвэрт гарсан өндөр настан, анагаах ухааны чиглэлээр суралцаж буй оюутнуудын судалгаатай болсон. Ковидын цар тахлын голомтод давхардсан тоогоор 895 эмнэлгийн ажилтан ажилласан ба эдгээр ажилтнуудыг сургалтад тогтмол хамруулж чадавхижуулллаа. | 90% |
| 2 | 1.2. | (Ковид-19) халдварт цар тахлын үед эрүүл мэндийн байгууллагуудын оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйжүүлэл тийн бодисыг урьдчилан нөөцлөх, түргэвчилсэн болон РТ-ПСР төхөөрөмжөөр | Улс, орон нутгийн төсөв | Оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, түргэвчилсэн болон РТ-ПСР төхөөрөмжөөр хангалт, ариутгал халдваргүйжүүлэл тийн бодисын нөөц | 2021 | Оношлуур 69,595 ширхэг эм, эмнэлгийн хэрэгсэл, 2,436,930 төгрөгийн тоног төхөөрөмж, 268 түргэвчилсэн болон РТ-ПСР төхөөрөмж 1 ш | Оношлуур 85,470 ширхэг эм, эмнэлгийн хэрэгсэл, 4,912,747 төгрөгийн тоног төхөөрөмж, 350, түргэвчилсэн болон РТ-ПСР төхөөрөмж 1 ш | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн молекул биологийн лабораторит 8366 иргэнд ковид болон томуугийн тандалтын шинжилгээг, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд антигенд суурилсан түргэвчилсэн оношлуураар 27258 иргэнд хийж, шинжилгээ хийх чадавхийг бүрдүүлсэн.<br>"Ковид-19" халдварт цар тахлын үед хэрэглэх 38 төрлийн 86,853 эм, 16 төрлийн 182,178 хувийн хамгаалах хэрэгсэл, 12 төрлийн 81,657 эмнэлгийн хэрэгслийн 14-30 хоногийн нөөцийг бүрдүүлж, эрүүл мэндийн байгууллагуудад ариутгал халдваргүйтгэлийн бодисын 21180 кг нөөцтэй байна. Баянгол, Сайхан, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хангана. | | | | | | Ерөө сумдын Эрүүл мэндийн төвүүдэд нийт 25,800,000 төгрөгийн уушигны багтаамж шалгах спирометр багаж болон дагалдах хэрэгсэл, ковидын дархлаажуулалт, вакцины хэмийн хяналтын системийг сайжруулахад 11,207,000 төгрөгийн багаж тоног төхөөрөмж нийлүүлж бэлэн байдлыг хангалаа. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн 26 байгууллагад 10,739.7 төгрөгийн санхүүжилтийг тухай бүр олгосон. | |
| 3 | 1.3. | Иргэд олон нийтэд (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, сэтгэл зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх ажлыг эрчимжүүлнэ. | Улс, орон нутгийн төсөв | (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах ухуулга сурталчилгаа | 2021 | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга сурталчилгааг 768 удаа хийж, 57128 иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө дэмжлэгийг үзүүлсэн. | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга сурталчилгааг 800 удаа хийж, 58000 иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө дэмжлэгийг үзүүлнэ. | Байгууллагын албан ёсны цахим хуудсаар дамжуулан 768 мэдээллийг олон нийтэд хүргэж 92930 таалагдсан сэтгэгдэл, 57128 хариу үйлдэл үзүүлж хандалт авсан байна.<br>3 телевизтэй гэрээ байгуулан (Ковид-19) цар тахлын өдөр тутмын мэдээлэл, цаг үеийн нөхцөл байдлын тодруулга мэдээлэл, урьдчилан сэргийлэх 8 төрлийн зурагт хуудас, 10 төрлийн шторк, байршуулан бусад ухуулга сурталчилгааны олон талт ажлыг иргэд, олон нийтэд цацан, 1,700,000 төгрөгийг зарцуулсан байна.<br>”Эмч зөвлөж байна” булангаар 275 төрлийн мэдээлэл, сургалт сурталчилгааг давхардсан тоогоор 536256 иргэнд хүргэж, 17 сумд, 6 тосгодын Эрүүл мэндийн төвд нийгмийн эрүүл мэндийн ажилтнаар ахлуулсан 3 хүний бүрэлдэхүүнтэй “Мэдээлэл түгээгч” сайн дурын бүлгийг байгуулж, шинэ коронавирусын халдвараас сэргийлэх сургалт сурталчилгаа, мэдлэг хандлагыг сайжруулах, буруу ташаа мэдээллийг залруулах зорилгоор 46 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төрлийн мэдээллийг боловсруулан орон нутгийн цахим сайт, пэйж хуудсуудаар түгээн 26395 хандалт авч, 1456 удаа хуваалцсан байна. | |
| 4 | 1.4. | (Ковид-19)цар тахлын дэгдэлтийн үед эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг эн тэргүүнд шийдвэрлэж үйл ажиллагааг тасалдуулахгүй явуулах нөхцөл боломжоор хангана. | Улсын төсөв | (Ковид-19) цар тахлын дэгдэлтийн үед санхүүжилт авах эрүүл мэндийн байгууллага, санхүүжилт | 2021 | 26 эрүүл мэндийн байгууллагад 10739.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгоно. | 28 эрүүл мэндийн байгууллагад 15000.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгоно. | Аймгийн нэгдсэн эмнэлэг, Мандал сумын эмнэлэг, Баянгол, Ерөө, Сайхан, Шаамар сумдын Эрүүл мэндийн төвд ковидын тасагт хэвтэн эмчилгээний зардалд 983 даатгуулагчийн 1371,6 сая төгрөг, 20 сум, тосгоны Эрүүл мэндийн төв, 5 өрхийн Эрүүл мэндийн төвийн ковидын гэрийн хяналтад нийт 7033 даатгуулагчийн 1125,3 сая төгрөгийн зардал олголоо. Мөн ковид-19 өвчний эсрэг дархлаажуулалтын зардалд давхардсан тоогоор 16074 даатгуулагчийн 80,4 сая төгрөг, ПСР шинжилгээнд 7688 даатгуулагчийн 384,4 сая төгрөг, ПСР шинжилгээний сорьц тээвэрлэх зардалд 6968 даатгуулагчийн 34,8 сая төгрөг буюу нийт давхардсан тоогоор 38746 даатгуулагчийн 2,996,5 төгрөгийг 28 эрүүл мэндийн байгууллагуудад бүрэн олголоо. | 100% |
| 5 | 1.5. | Томуу, томуу төст өвчин, улаанбурхан, улаануud зэрэг амьсгалын замын халдварт өвчнөөс | Улсын төсөв | Дархлаажуулалтад хамрагдах сургууль цэцэрлэгийн хүүхдүүд | 2021 | Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн 90-ээс хувийг дархлаажуулалтад хамруулсан. | Сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийн 93-аас дээш хувийг дархлаажуулалтад хамруулна. | Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаажуулалтад 1-12 насны цэцэрлэгийн насны 6450 хүүхдэд дархлаажуулалт хийгдэхээс 13610 хүүхэд буюу 85 хувьтай хамрагдаж | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сэргийлэх дархлаажуулалтад сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг хамруулах ажлыг зохион байгуулна. | | | | | | байна. Томуугийн өвчлөл 45-р 7 хоногийн байдлаар амбулаторийн үзлэгт ээлэх томуу, томуу төст өвчин 6,8 хувь буюу улирал хоорондын түвшинд байна. Улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг нэмэлт дархлаажуулалтыг сургууль, цэцэрлэгийн насанд хийгдээгүй, товлолын дархлаажуулалтын хамралт 99 хувьтай байна. | 100% |
| 6 | 1.6. | “Ухаалаг цахим сургалт”-ын орчинг нэмэгдүүлэн, хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, багш нарын мэдлэг ур чадвар, эцэг эхчүүдийн оролцоог дээшлүүлнэ. | Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр | Цахим хичээлийн сан, төгсөх, дэвших ангийн шалгалт, хөндлөнгийн болон чанарын үнэлгээ, элсэлтийн ерөнхий шалгалтын оноог ахиулах даалгаврын сан Зөөврийн компьютераар хангагдсан багш нар | 2021 | Бага ангийн 2 судлагдахуунаар цахим хичээлийн санг бүрдүүлж, Бага боловсролын төгсөх, дэвших 6 судлагдахуунаар даалгаврын санг бүрдүүлж, 100 багшийг хангасан. | Бага, суурь, бүрэн дунд боловсролын 3 судлагдахуунаар цахим хичээлийн санг бүрдүүлнэ. Суурь боловсролын төгсөх, дэвших 13 судлагдахуунаар даалгаврын санг бүрдүүлнэ. 100 багшийг хангана. | БНСУ-ын Жэжү тусгай мужийн Боловсролын газраас Сүхбаатар сумын 1-р сургуульд 170.0 сая төгрөг, Цагааннуур сумын сургуульд 250.0 сая төгрөгийн мэдээлэл харилцааны технологийн кабинетийг хүлээлгэж өгснөөр 5 сургууль мэдээлэл харилцааны технологийн иж бүрэн кабинеттай болж, улсын төсвийн 1396,6 сая төгрөгийн санхүүжилтээр багшийн хөгжил, сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах, цахим ангийг байгуулахаар сургалтын 15 ширхэг суурин компьютер, 15 ширхэг зөөврийн компьютер-15 ширхэг, сургалтын таблет 943 ширхэг, 9 ширхэг ухаалаг дэлгэц самбарыг нийлүүлж 35 сургуулийн багш нарыг цахимаар сургалт явуулах боломжийг хангаад байна.<br>Хичээл, сургалтын үйл ажиллагаа нь танхимын хэлбэрээр тасралтгүй явагдаж, БШУЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэн зэрэг байгууллагуудаас манлайллын ур чадвар, сургалтын технологийн шинэчлэл зэрэг сургалтуудыг үе шаттай зохион байгуулж, давхардсан тоогоор 6096 багш, ажилтныг хамруулж чадавхжууллаа. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Багшийн хөгжлийг дэмжих цахим дата авахад зориулж сургуульд 298,2 сая төгрөг, цэцэрлэгт 40,2 сая төгрөгийг төлөвлөн санхүүжилтийг олголоо. Цаг хугацаа, газар зүйн байршлаас үл хамаарч технологийн дэвшлийг ашиглан 16687 суралцагч, эцэг эх, асран хамгаалагчдад цахим сургалт зохион байгууллаа. | |
| 7 | 1.7. | Нийгмийн халамж, даатгал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдах иргэдэд банк, төлбөр тооцооны цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ. | Улсын төсөв | Нийгмийн халамжийн үйлчилгээ авсан иргэн, Нийгмийн даатгалын сангаас цахим болон картаар өндөр нас, тэжээгчээ алдсан, тахир дутуугийн тэтгэвэр авагч иргэд | 2021 | 1756 иргэнд үйлчилгээг хүргэж, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдыг 100 хувь хамруулсан. | 1760 иргэнд үйлчилгээг хүргэн, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдыг 100 хувь хамруулна. | “Нийгмийн халамжийн нэгдсэн систем”-ийг нэвтрүүлэн нийгмийн халамжийн 14 төрлийн үйлчилгээг цахимжуулж, 75546 иргэд 63308.4 сая төгрөгийг олгох үйлчилгээг үзүүллээ. Нийгмийн даатгалын сангаас өндөр нас, тэжээгчээ алдсан,хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчдыг картжуулах, тэтгэвэр авагчдын тэтгэврийн дэвтрийг цахимжуулах ажлын банкуудтай хамтран бүрэн хэрэгжүүллээ. | 100% |
| 8 | 1.8. | Онцгой нөхцөл байдлын үед гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах тусламж дэмжлэг үзүүлэх, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлнэ. | Улсын болон орон нутгийн төсөв | Онцгой нөхцөл байдлын үед мэргэжлийн ангиар дамжуулан хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхэд, урьдчилан сэргийлэх, нөлөөллийн ажил, арга хэмжээ, хамрагдсан иргэд | 2021 | Дэмжлэг туслалцаа авах шаардлагатай 150 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн. Нөлөөллийн 3 арга хэмжээ цахимаар зохион байгуулж 900 иргэнийг хамруулсан. | Дэмжлэг туслалцаа авах шаардлагатай 200 хүүхдэд шууд хүрч үйлчилнэ. Нөлөөллийн 5 арга хэмжээ цахимаар зохион байгуулж 1000 иргэнийг хамруулна. | Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 590 хүүхдэд 2 удаагийн үнэлгээ хийж, 8 төрлийн хариу үйлчилгээнд хамрууллаа. Үүнд:<br>-Өндөр болон дунд эрсдэлтэй 200 хүүхдийг “Индиго” даатгалын үйлчилгээнд<br>-Сэтгэл зүйн үйлчилгээнд-256,<br>-Эрүүл мэндийн үйлчилгээнд-187,<br>-Нийгмийн халамжийн үйлчилгээнд-389,<br>-Хүнсний багцад-15<br>-Эрүүл мэндийн багцад-15<br>-Ахуйн багцад-25<br>-Тэргэнцэр 2 нийт 8 төрлийн хариу үйлчилгээнд давхардсан тоогоор 1089 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хүүхдийг хамруулан 6,5 сая төгрөг, Хүчирхийллийн хохирогч хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд 13,3 сая төгрөгийг зарцуулж, Улаан загалмайн нийгэмлэг, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр коронавирусын халдвар туссан бага насны 100 хүүхдүүд, асран хамгаалагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг үзүүллээ.<br>Ерөнхий боловсролын сургуулийн 5-12 дугаар ангийн 520 сурагчдад "Газар хөдлөлтийн үед авах арга хэмжээ" сэдэвт сургалтыг Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулж, “Өсвөрийн аврагч” бүлгийн 85 гишүүдэд чадавхжуулах дадлага ажлыг зохион байгууллаа. Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор байгууллагын цахим хуудсаар 5 төрлийн мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлэг, шторкийг түгээн 410 хандалт авч, 300 удаа шэйрлэж, 3 удаагийн сургалт, 1 нөлөөллийн ажил арга хэмжээн зохион байгуулж, 1100 иргэд хамрагдлаа.<br>Сургууль цэцэрлэгийн орчинд “Гамшгийн эрсдэлийг бууруулах, хүүхдэд ээлтэй гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г боловсруулах арга зүйн сургалт зохион байгуулж, 35 сургууль, 44 цэцэрлэг гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөтэй боллоо. | |
| 9 | 1.9. | Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн өрх, иргэдэд үзүүлэх халамж, эрүүл мэндийн тусламж, | Улсын төсөв | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг авсан Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн өрх, иргэд | 2021 | 7570 иргэдэд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг үзүүлсэн. | 7953 иргэдэд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг үзүүлнэ. | Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн иргэнд хүнсний эрхийн бичиг олгох журмын дагуу шаардлага хангасан 442 өрхийн 2525 иргэнд 300.1 сая төгрөгийн үйлчилгээг | 30% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | үзүүллээ. | |
| 10 | 1.10. | Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг орон нутгийн төсвийн боломжид үндэслэн төлөвлөн батлуулж, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, халдвар хамгааллын хэрэгслээр мэргэжлийн байгууллагуудыг хангана. | Орон нутгийн төсөв | (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, халдвар хамгааллын хэрэгслээр хангасан тоо | 2021 | Цар тахлын үед хэрэглэх шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл багаж тоног төхөөрөмж, оношлуур бусад хэрэгсэл худалдан авахад зарцуулагдах төсөв батлагдсан байна | Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, халдвар хамгааллын хэрэгслээр мэргэжлийн байгууллагуудыг хангана. | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар: Ерөө сумын эрүүл мэндийн төвд 15.0 сая төгрөгийн өртөгтэй цусны дэлгэрэнгүй тодорхойлогч аппарат, 19.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сант сумын эрүүл мэндийн төвд “Toyota prius 20” загварын автомашин, 30.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Орхон сумын Эрүүл мэндийн төвд 15-20 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж, 80.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлгүүдийг тус бүр чих, хамар, хоолойн дурангийн тоног төхөөрөмжөөр хангалаа. Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламж, НҮБ-ийн Хүүхдийн сангаас 64,964,865 төгрөгийн өртөг бүхий 9 төрлийн 35 ширхэг нярайн болон вакцины тоног төхөөрөмжийг нийлүүллээ. | 100% |
| 11 | 1.11. | Коронавируст халдвар (Ковид-19)-ын эдийн засагт үзүүлэх нөлөөг багасгах зорилгоор Засгийн | Орон нутгийн төсөв | Эдийн засагт үзүүлэх нөлөөг багасгах зорилгоор дэмжигдсэн жижиг, дунд | 2021 | Жижиг, дунд бизнес эрхлэгчид, тариаланч, ногоочдын нэгдсэн | Жижиг, дунд бизнес эрхлэгчид, тариаланч, ногоочдын нэгдсэн судалгааг гаргаж, хөнгөлөлттэй зээл | “Ажлын байр дэмжих” зээлийн хүрээнд арилжааны банкуудад 1290 аж ахуйн нэгж, иргэдээс 121.5 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт ирснээс 727 аж ахуйн нэгж иргэдэд 39.6 тэрбум төгрөгийн 3 хувийн хүүтэй зээл | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | газраас хэрэгжүүлж буй бодлогыг орон нутагт зохион байгуулж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллана. | | бизнес эрхлэгчдийн тоо | | судалгааг гаргаж, хөнгөлөлттэй зээл тусламжид хамруулсан. | тусламжид хамруулна. | олгогдсон.<br>Мөн 68 аж ахуйн нэгж, иргэд 2,8 тэрбум төгрөгийн өндөр хүүтэй зээлээ хүү багатай зээл рүү шилжүүлсэн байна. “Хөдөө аж ахуйг дэмжих” зээлийн хүрээнд арилжааны банкуудад газар тариаланд 79 аж ахуйн нэгж, иргэдээс 6,7 тэрбум төгрөгийн хүсэлт ирүүлснээс 55 аж ахуйн нэгж иргэнд 3.0 тэрбум төгрөг, малчдыг дэмжих зээлд 1182 аж ахуйн нэгж, иргэдээс 14,5 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт ирснээс 782 малчинд 8,7 тэрбум төгрөг нийтдээ 837 аж ахуйн нэгж иргэдэд 11,7 тэрбум төгрөгийн 3 хувийн хүүтэй зээл олгож, шинээр 225 ажлын байр бий болж 1240 ажлын байр хадгалагдан үлдлээ.<br>“Сум хөгжүүлэх сан”-гийн 955 зээлдэгчийн мэдээллийг Монгол банкны мэдээллийн санд оруулж, 137 зээлдэгчид 1247,0 сая төгрөг зээлийг олгож, шинээр 183 ажлын байр бий болж, өмнөх оныхоос зээлийн эргэн төлөлт 86,7 хувиар өссөн байна. Хоршоо хөгжүүлэх сангаас 15 зээлдэгчид 255,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгож, шинээр 27 ажлын байр бий болж жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллалаа. | 100% |
| **ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | |
| **2.1.Эрүүл мэнд** | | | | | | | | | |
| **Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, оношилгоо, эмчилгээнд "Ухаалаг цахим" технологийг нэвтрүүлнэ.** | | | | | | | | | |
| 12 | 2.1.1. | Хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, | Улс, аймгийн төсөв | Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлгийн цогц үзлэг, оношилгоонд хамрагдсан иргэн, | 2021 | 4-5 сум, тосгоны хүн амын 76 хувиас дээш хувийг хамруулж, 4-5 сумын зорилтот бүлгийн хүн | 4-5 сум, тосгоны хүн амын 80 хувиас дээш хувийг хамруулж, 4-5 сумын зорилтот бүлгийн хүн амын 70-аас | “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо шинжилгээнд 108,887 иргэн хамрагдахаас өнөөдрийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | оношилгоо, шинжилгээг тасралтгүй зохион байгуулна. | | Уушигны эмгэг илрүүлэх үзлэгт хамрагдсан иргэн | | амын 65-аас дээш хувийг хамруулсан. | дээш хувийг хамруулна. | байдлаар 24,695 иргэн хамрагдаж, 22.6 хувьтай, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт насанд хүрэгчдийн буюу 18-аас дээш насны эрт илрүүлэгт 74586 иргэн хамрагдахаас 2777 иргэн хамрагдаж, 3,7 хувьтай байна.<br>Насанд хүрэгчдийн 4 эрт илрүүлгийн багцанд:<br>1. 18-30 насанд 21908 иргэнд хамрагдахаас 1397 иргэн хамрагдаж, 6,4% хувь<br>2. 31-45 насанд 24774 иргэнд хамрагдахаас 608 иргэн хамрагдаж, 2,5% хувь<br>3. 46-60 насанд 19074 иргэнд хамрагдахаас 519 иргэн хамрагдаж, 2,8% хувь<br>4. 61-ээс дээш 8793 иргэнд хамрагдахаас 253 иргэн хамрагдаж, 2,9% хувьтай байна.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллага буюу сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвд 0-17 насны 38739 хүүхэд эрт илрүүлэг үзлэг оношилгоонд хамрагдахаас 21918 хүүхэд хамрагдаж, 56,6% хувьтай байна. | 90% |
| 13 | 2.1.2. | Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх “Эрүүл, идэвхтэй амьдрал”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн | Улс, аймгийн төсөв | “Эрүүл, идэвхтэй амьдрал”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Эрүүл гэр бүл-Эрхэм | 2021 | Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх хөтөлбөрт иргэдийн 25 хувь нь хамрагдаж, эхийн эндэгдлийн түвшин-100.000 амьд төрөлтөд 0, Тав хүртэлх | Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх хөтөлбөрт иргэдийн 30 хувь нь хамрагдаж, Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөр"ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл | “Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 25 ажил төлөвлөснөөс 22 ажлыг хэрэгжүүлж 88 хувьтай байна.<br>“Архигүй амьдралыг цогцлооё”, “Эрүүл зүрхний төлөө”, Сэлэнгэ аймаг 100км-ийн алхалт, “Унаж бэртэх осол гэмтлээс сэргийлье”, “Эерэг хандлага-Эрүүл оюутан”, ”Дэлхийн охидын өдөр”, “Эрүүл аюулгүй ажлын байр” сэдэвт аян сургалтуудыг зохион байгуулж нийт 5896 иргэдийг хамруулж, ”Эмч зөвлөж байна” | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Монгол", "Харшлаас сэргийлэх", "Эрүүл гэр бүл-Эрхэм баян" арга хэмжээг зохион байгуулна. | | баян" арга хэмжээний хэрэгжилтийн хувь | | насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд 10.0 промил, Нялхсын эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд 5.8 промил, Амьгүй төрөлтийн түвшин 7.5 промил, Жирэмсний хяналтын хувь 88 хувь | ажиллагааны 25 хувь нь хамрагдан, эхийн эндэгдлийн түвшин-100.000 амьд төрөлтөд 0, Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд 9.5 промил, Нялхсын эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд 5.7 промил, 4Амьгүй төрөлтийн түвшин 7.0 промил, Жирэмсний хяналтын хувь 89 хувь | булангаар 275 төрлийн мэдээлэл, сургалт сурталчилгааг давхардсан тоогоор 536256 иргэдэд цахимаар түгээж, 52395 иргэдэд мэдээлэл хүрсэн байна.<br>"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээг эрчимжүүлснээр халдварт өвчний 7742 тохиолдол буюу 10000 хүн амд 683,2 промилл ноогдож байгаа нь урьд оны мөн үеэс 2359 тохиолдол буюу 42,4 промиллоор буурсан үзүүлэлттэй байна.<br>Нийт халдварт өвчний 95,8 хувийг коронавирусын халдвар эзэлж байна. Өрхийн эрүүл мэндийн 5 төвүүдтэй гурвалсан гэрээг байгуулж, оношлогоо, шинжилгээний багаж тоног, төхөөрөмжөөр хангаж, Дэээрэт Олон Улсын энэрлийн байгууллагаас 84,111,500 төгрөгийн 5 нэр төрлийн 55 багаж тоног төхөөрөмжүүдийг 16 сумд, 3 тосгодын эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хандивлаж, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт 5 нэр төрлийн 38,232,500 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг нийлүүлснээр эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарт ахиц гарлаа. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт ургийн анатомийн бүтэц тодорхойлох 4D эхо аппаратыг ажиллуулж, эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслыг шинээр эмчилгээ үйлчилгээнд нэвтрүүлснээр эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээг үзүүлэх багаж тоног төхөөрөмжийн хангалт өмнөх оныхоос 46,2 хувиар буюу 8 төрлөөр нэмэгдсэн. Эрүүл мэндийн яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, АШУҮИС-тай хамтран ажлын байрны онол дадлага хосолсон сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 212 эмч, эмнэлгийн мэргэжилтэнг хамруулллаа. Үр дүнд эхийн эндэгдэлгүй, нярайн эндэгдэлийг бодит тоогоор 5 тохиолдлоор бууруулан ажиллалаа. "Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулах" 8 төрлийн хавдар илрүүлэх шинжилгээ оношлогоонд 31-ээс дээш насны нийт 2804 хүн хамрагдаж, ходоодны хавдар 1, элэгний үүсгэвэр 9 хавдрын урьтал 68 тус тус илэрсэн байна. Илэрсэн өвчлөлийг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэн, онош тодруулах, эмчилгээ хяналтад авч ажилласан. Хөх, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 5593 зорилтот насны эмэгтэйчүүд хамрагдахаас 2051 буюу 36,7 хувь нь хамрагдаад байна. "Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн хүрээнд эрт илрүүлгийн үзлэгт нийт 74549 иргэн хамрагдахаас 25323 иргэн буюу 35,3 хувь нь хамрагдлаа. Харшлаас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 73.3 хувьтай байна. | |
| 14 | 2.1.3. | "Хорт хавдараас урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх тусламж | ОУБ-ын дэмжлэгтэй, орон нутгын санжүүжил | Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлгүүдэд ашиглалтад орсон | | Аймгийн нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасагт хавдар, хөнгөвчлөх | Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт хавдрын тасаг нээх бэлтгэл ажлыг хангана. | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хорт хавдарыг эмчлэх тасаг нээж, Хавдар судлалын үндэсний төвтэй гэрээ байгуулж, эмч нарыг сургах, хавдрын эмчийг бэлтгэхэд хамтран ажиллаж | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үйлчилгээний иж бүрэн тасаг”-ийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт шинээр нээж ажиллуулна. | т | хавдрын тасаг | 2021 | эмчилгээний 5 ортой бөгөөд 2021 онд 64 иргэн хэвтэн эмчлүүлсэн. Мандал сумын нэгдсэн эмнэлэгт хөнгөвчлөх эмчилгээний 2 ортой 2021 онд 54 иргэн үйлчлүүлсэн байна. | | байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт тус бүр 1 их эмч хавдрын өвчлөлийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2022 оны байдлаар Нэгдсэн 2 эмнэлэгт нийт 50 хүн хэвтэн эмчлүүлж хавдрын хөнгөвчлөх тусламж үйлчилгээ авсан байна. Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт хавдрын тасаг нээх төсөл боловсруулж, аймгийн Нэгдсэн эмнэлэгт хорт хавдарыг эмчлэх тасагт шаардлагатай хөрөнгө оруулалтын саналыг уламжлаад байна. ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улсын Улан-Үдэ хотноо шинээр нээгдсэн Цөмийн анагаах ухааны оношилгооны төвд хорт хавдартай 10 иргэдийг эмчлүүлэхээр боллоо. | 50% |
| 15 | 2.1.4. | Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна | Орон нутгийн болон улсын төсөв | Цахим технологийг нэвтрүүлэн үзлэгийн цаг авах болон эрүүл мэндийн зөвлөгөө өгөх эрүүл мэндийн байгууллага | 2021 | Эрүүл мэндийн 29 байгууллагаас иргэдэд цахим зөвлөгөө өгөх ажлыг нэвтрүүлж, 372,444 үзлэгийн цаг олгож ажиллана. | Эрүүл мэндийн 29 байгууллагаас иргэдэд цахим зөвлөгөө өгөх ажлыг нэвтрүүлж, 772,444 үзлэгийн цаг олгож ажиллана. | “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг “E-Health” программыг нэвтрүүлснээр амбулаторийн цахим бүртгэл, үзлэгийн кабинетууд болон тасгууд, лаборатори хоорондоо цахимаар холбогдон оношлогоо, үзлэгийн дугаар авах, шинжилгээнд илгээх, хариу авах, яаралтай тусламжийг эрэмбэлэн цаг алдалгүй оношлогоо шинжилгээнд илгээх, хариуг хүргэх ажлууд шуурхай болсон. Амбулаторийн үзлэгийн цаг товлолыг “E-Health” программаар давхардсан тоогоор 107625 үйлчлүүлэгчид 830973 цаг захиалсан байна. | 100% |
| 16 | 2.1.5. | Мэргэжлийн өндөр ур чадвартай, туршлагатай нарийн | Улс, орон нутгийн төсөв | Сэлгэн ажилласан, сургалтад хамрагдсан, | 2021 | Сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний | Сэлгэн ажилласан эмнэлгийн мэргэжилтний тоо 25, сургалтад | “Улаанбаатар мэд” эмнэлгийн томографийн эмчийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт, Ерөө сумын эрүүл мэндийн төвд Дархан-Уул аймгийн Нэгдсэн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтныг гэрээний тусгай нөхцөлтэйгээр ажиллуулах, гадаад, дотоодод туршлага судлуулах, давтан сургах арга хэмжээг үе шаттай зохион байгуулна. | | гадаад дотоодод туршлага судлуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо | | тоо 25 | хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо 28, сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо 15 | эмнэлгийн шүдний 1 эмч, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт УБ хотоос 1 шүдний эмч, аймгийн Нэгдсэн эмнэлэгт мэс заслын 1 эмчтэй гэрээ байгуулан ажиллуулж байна.<br>Ерөө сумын Эрүүл мэндийн төвийн дотрын их эмч Бүгд найрамдах Солонгос улсад Хоол боловсруулах эмгэг судлалын сургалтад хамрагдаж, Чих хамар хоолой судлал, дүрс оношилгоо судлал, мэс засал судлал, гэмтэл судлал, дотор судлал, хүүхэд судлалын чиглэлээр нийт 6 их эмч үндсэн мэргэшил олгох сургалтад, нэн шаардлагатай эсийн эмгэг судлал, хүүхдийн хоол боловсруулах тогтолцоо судлалын төрөлжсөн сургалтад тус бүр 1 их эмч, халдварт, яаралтай, дархлаажуулалт, гемодиализын сувилахуй судлал, гэмтлийн сувилахуй, мэс заслын сувилахуй судлалаар нийт 10 сувилагчийг төсвийн сангийн санхүүжилтээр сургаж байна.<br>УНТЭ-т мэс заслын эмч, сувилагчийг “Урологийн дуран”-ын ажлын байрны түргэвчилсэн 14 хоногийн сургалтад УНТЭ-т, Гэмтлийн сувилахуй, мэс заслын сувилахуй судлалаар Төрийн тусгай эмнэлэг, Гэмтлийн эмнэлэгт 4 сувилагч, Улсын гуравдугаар төв эмнэлэгт “Нүдний болор шилжүүлэн суулгах хагалгаа”-ны чиглэлээр нүдний их эмч, нүдний сувилагчийг 1 сарын ажлын байрны түргэвчилсэн сургалтад, Цус сэлбэлт судлалын үндэсний төвд -1 эмчийг тус тус ажлын байрны дагалдан сургалтад хамруулсан. Туршлага судлах уулзалтыг Монгол, Японы эмнэлэгт-14 хүн, УНТЭ-т 25 хүн мөн ЭХЭМҮТ, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ХӨСҮТ, ЭМХТ–үүдэд харьяа эрүүл мэндийн байгууллагуудаас эмч, эмнэлгийн мэргэжилтэн нийт 87 хүнийг дээд шатлалын эмнэлэгт ажлын байранд дадлагажуулан сургаж, сэлгэн ажиллуулсан. Мөн Глобал сантай хамтран цахимаар нийт 13 сувилагчийг сургалтад хамрууллаа. | |
| 17 | 2.1.6. | Яаралтай түргэн тусламжид агаарын тээврийн үйлчилгээг нэвтрүүлнэ. | Орон нутгийн болон улсын төсөв | Хүнд, хэвтрийн өвчтөнг хугацаа алдалгүй лавлагаа шатны эмнэлэгт шилжүүлэхэд агаарын тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх | 2021 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэдрэлийн тасагт тархины цус харвалт оноштой иргэнийг мэргэжлийн эмчийн хяналтан дор Улсын Хоёрдугаар эмнэлэг рүү агаарын тээвэрлэлтээр хугацаа алдалгүй шилжүүлсэн | Хүнд өвчтөнийг цаг алдалгүй шилжүүлнэ. | Тархины харвалт-2, шигдээс-1 нийт 3 өвчтөн агаарын тээврийн үйлчилгээг ашиглан лавлагаа шатлалын эмнэлэгт цаг алдалгүй хүргэж амь насыг авраад байна. | 100% |
| 18 | 2.1.7. | Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол олгож, “Эрүүл хүүхэд-Эрүүл Ирээдүй” эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эрүүлжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | Улсын төсөв | Эрүүл мэндийн боловсрол олгох танхим болон цахимаар сургалтад хамрагдсан хүүхэд,<br>Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан Сургууль цэцэрлэгийн хүүхдүүд | 2021 | ЭМЯ, НЭМ санхүүжилтээр гарын авлага, тараах материалаар сургууль цэцэрлэгүүдийг хангасан.<br>Орон нутгийн ТВ-үүдтэй гэрээ байгуулж,<br>8 удаагийн сургалтад 484 хүүхэд хамрагдсан. 0-17 | Танхимаар болон цахимаар сургалтад 800 хүүхдийг хамруулна.<br>Хүүхдүүдийн 60 хувийг эрт илрүүлэх үзлэгт хамруулсан байна. | Дэлхийн гар угаах өдөр, усны өдөр, хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх, Эхийн сүүгээр хооллолтын 7 хоног, Тамхи, архитай тэмцэх өдөр, Сэтгэцийн эрүүл мэндийн өдрүүд болон эрүүл идэвхтэй амьдралын чиглэлээр танхимаар 1256 хүүхдийг сургалтад хамруулж нөлөөллийн сурталчилгааг хийж, 35 төрлийн эрүүл мэндийн боловсрол олгох инфографик боловсруулан 2536 иргэд, хүүхдүүдэд хүргэсэн. “Сэлэнгэ түмэн” цахим телевизтэй хамтран гар угаах, маскаа зүүх, зөв найтааж, ханиах зэрэг видео шторк бэлтгэн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | насны 293 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, өвчлөлийг илрүүлэн, эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан. Эрүүлжилтийн хувь 82 хувьтай. | | цахим хуудсуудаар түгээсэн. "Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд 0-18 насны хүүхдийн эрт үзлэгт хамрагдвал зохих 38739 хүүхдээс нийт 17038 буюу 44.0 хувийг нь хамрууллаа. "Эрүүл-шүд" хүүхдийн шүдний өвчлөлийг эрт илрүүлэх, эмчлэх үзлэг зохион байгуулж, Сүхбаатар сумын 160 хүүхэд, Зүүнбүрэн сумын 570 хүүхдийг хамруулснаас 342 хүүхэд, шүдний өвчлөлтэй илэрч, эмчлэх ажлыг зохион байгуулж байна. Монгол Улсын 29 дахь Ерөнхий сайд, УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатын ажлын албатай хамтран Сайхан, Ерөө бүсийн сумдын 1284 хүүхдийг шүдний үзлэг эмчилгээнд хамрууллаа. | |
| 19 | 2.1.8 | Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ. | Улсын төсөв | Цахим жорын систем нэвтрүүлсэн эмийн сан | 2021 | Цахим жорын систем нэвтрүүлсэн эмийн сан 55 | Цахим жорын систем нэвтрүүлсэн эмийн сан-57 | Эрүүл мэндийн байгууллагын эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд 29 төрлийн 351,525 эм, 13 төрлийн 452,900 эмнэлгийн хэрэгсэл, 15 төрлийн 785,800 ширхэг хувийн хамгаалах хэрэгсэлийг хангалаа. Эмнэлгүүдэд хэрэглэх эм эмнэлгийн хэрэгслийг нэгдсэн тендер зарлаж шалгарсан компаниудаас хямд үнэтэй, чанарын баталгаатай, эм хэрэгслийг авч хэрэглэж, зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 98 хувьтай байна. Цахим жорын систем нэвтрүүлсэн 57 эмийн сан иргэдэд үйлчилж байна. | 100% |
| 20 | 2.1.9 | Зарим сумын Эрүүл мэндийн | Улс, орон нутгийн | Сумын Эрүүл мэндийн төвд | 2021 | Сумын ЭМТ-д ажиллаж байгаа | Сумын ЭМТ-д ажиллаж байгаа | Сумын эрүүл мэндийн төвд шүдний 7 эмч, 5 сувилагч ажиллаж байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төвүүдийг шүдний эмчээр хангаж, шүдний кабинеттай болгоно. | төсөв | ажиллаж байгаа шүдний эмч, сувилагч | | шүдний эмчийн тоо-7, сувилагчийн тоо-6 | шүдний эмчийн тоо-8, сувилагчийн тоо-8 | Цагааннуур сумын Эрүүл мэндийн төвд 1 иргэний 22.0 сая төгрөгийн хандиваар шүдний тоног төхөөрөмжтэй болж үзлэг оношлогоог хийх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 90% |
| 21 | 2.1.10 | ”Тусгай хэрэгцээт иргэн, хүүхдийг эмчлэх, сувилах, сэргээн засах тасаг”-ийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт шинээр нээж, протез, ортопедын техник, технологийн үйлчилгээг бий болгоно. | Орон нутгийн болон улсын төсөв | Шинээр нээгдсэн сэргээн засах тасаг | 2021 | Тусгай хэрэгцээт иргэн, хүүхдийг эмчлэх, сувилах, сэргээн засах тасгийг нээж ажиллуулах бэлтгэл хангасан. | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Тусгай хэрэгцээт иргэн, хүүхдийг эмчлэх, сувилах, сэргээн засах тасгийг нээж ажиллуулсан байна. | ”Тусгай хэрэгцээт иргэн, хүүхдийг эмчлэх, сувилах, сэргээн засах тасаг”-ийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт шинээр нээхээр бэлтгэл ажил хангалаа. Сэргээн засах судлалаар үндсэн мэргэшлийн сургалтад төрийн сангийн зардлаар 1 их эмчийг сурган бэлтгэж байна. | 50% |
| 22 | 2.1.11 | “Хачигт халдварын оношилгооны загвар төв”-ийг байгуулж, Сүрьеэгийн эмнэлгийг бие даасан байртай болгоно. | Орон нутгийн болон улсын төсөв | Ашиглалтад орсон “Хачигт халдварын оношилгооны загвар төв, сүрьеэгийн эмнэлэг | 2021 | Зураг төслийг эцсийн байдлаар болгон санхүүжилтын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэхээр ажиллаан. | ЗӨСТ-н дэргэд “Хачигт халдварын оношилгооны загвар төв”-ийг байгуулах ажлыг эхлүүлнэ. Сүрьеэгийн эмнэлгийн байгуулах ажлыг эхлүүлнэ | Зоонoз өвчин судлалын төвийн дэргэд “Хачигт халдварын оношилгооны загвар төв”-ийг байгуулах санал, үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсрууллаа.<br>2023 оны 04 дүгээр сард ОХУ-ын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллахаар товлоод байна.<br>Сүрьеэгийн эмнэлэг байгуулах ажил төсвөөс шалтгаалан хэрэгжээгүй. | 30% |
| 23 | 2.1.12 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дэргэд “Эрүүл мэндийг дэмжих төв”, Эмгэг судлалын лаборатори, | Орон нутгийн болон улсын төсөв | Ашиглалтад орсон эрүүл мэндийг дэмжих төв, эмгэг судлалын лаборатори, хүчилтөрөгчийн | | Эрүүл мэндийн яам болон Эмгэг судлалын үндэсний төвийн хөрөнгө оруулалтаар | Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулах ажлыг эхлүүлж, эмгэг судлалын лабораторийн | Улсын төсвийн 340.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт олон улсын стандартад нийцсэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх чиглэлийн нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ, | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт “Хүчилтөрөгчийн үйлдвэр”-ийг ашиглалтад оруулна. | | үйлдвэр | 2021 | аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эмгэг судлалын лабораторийн Микротом тоног төхөөрөмж, туслах багаж хэрэгсэлүүдийг нийлүүлснээр ашиглалтад оруулж нийт 126 биопси шинжилгээ хийгдсэн. | шинжилгээ хийж, хүчилтөрөгчийн үйлдвэрийн зураг төсвийг батлуулж, ашиглалтад оруулна. | оношилгооны иж бүрэн төв болох “Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг шинээр ашиглалтад оруулж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс үйл ажиллагааг эхлүүллээ.<br>Эрүүл мэндийн яам болон Эмгэг судлалын үндэсний төвийн хөрөнгө оруулалтаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эмгэг судлалын лабораторийн Микротом тоног төхөөрөмж, туслах багаж хэрэгсэлүүдийг нийлүүлснээр 2022 онд нийт 311 амьд ахуйн шинжилгээ, задлан шинжилгээ 23 орсон, 3000 гаруй цитлогийн шинжилгээ хийгдсэн.<br>“Бороо гоулд” ХХК-ийн 300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт 2022 оны 11 дүгээр сард “Хүчилтөрөгчийн бүрэн автомат үйлдвэр”-ашиглалтад орсноор сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасаг болон ковидын эмчилгээний өрөөнүүдэд хүчилтөрөгчийг шууд дамжуулах нөхцөл бүрдлээ. | 100% |
| 24 | 2.1.13 | “Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийн төв”-ийг байгуулна. | Улсын төсөв | Ашиглалтад орсон тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийн төв | 2021 | Улсын төсөвт 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр “Нөхөн сэргээх хүүхэд хөгжил, сургалтын төв”-ийн барилгыг Сүхбаатар суманд барихаар тусгагдсан. | Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийн төвийг байгуулна. | Тусгай хэрэгцээт хүүхдийг сувилах хөгжүүлэх чиг үүрэгтэй “Хүүхдийн сувиллын ясли” нь орон нутгийн 204,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар төмөр замын байгууллагаас шилжин ирсэн цэцэрлэгийн барилгад засвар хийж 2022 оны 12-р сард ашиглалтад оруулж 58 хүүхэд хамрагдаж байна. Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн сурах орчинг бүрдүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зорилгоор төсөл саналыг ЭМЯ, БШУЯ-нд уламжлаад байна. | 50% |
| 25 | 2.1.14 | Эмч, эмнэлгийн ажилтнуудын тогтвор | Улс, орон нутгийн төсөв | Орон сууцаар хангагдсан эмнэлгийн | | Орон сууцаар хангагдсан эмнэлгийн | Орон сууцаар хангагдсан эмнэлгийн | Төрийн албан хаагч нарт зориулан урьдчилгаа төлбөргүй, хүүгүй 120 айлын орон сууц хөтөлбөрт 20 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | суурьшилтай ажиллах нөхцөлийг хангаж, мэргэжлийн ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагыг дээшлүүлнэ. | | ажилтан, Мэргэжлийн ёс зүйн сургалтад хамрагдсан эмнэлгийн ажилтан | 2021 | ажилтны тоо-7, Сургалтад хамрагдсан эмнэлгийн ажилтны тоо-650 | ажилтны тоо-12, Сургалтад хамрагдсан эмнэлгийн ажилтны тоо-715 | эмнэлгийн ажилтан худалдан авах гэрээ хийж хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцны зээлд хамрагдаж, Баянгол, Жавхлант, Сант, Цагааннуур, Алтанбулаг сумдын эрүүл мэндийн төв нь аж ахуйн аргаар 14 айлын орон байрыг барьж ашиглалтанд оруулж, 14 ажилтныг байраар хангалаа.<br>Ёс зүйн чиглэлээр зохион байгуулсан 13 удаагийн цахим сургалтад 417 албан хаагчид, 31 удаагийн сургалт, хэлэлцүүлэг, ярилцлагад давхардсан тоогоор 825 гаруй эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд хандсан ёс зүйн сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлж Эрүүл мэндийн яамны 11-11 төв, аймгийн 7036-1111, Эрүүл мэндийн газрын дэргэдэх ёс зүйн салбар хороонд ирүүлсэн иргэдийн гомдол саналыг шуурхай шийдвэрлэж байна. | 100% |
| **2.2. Боловсрол** | | | | | | | | | |
| **Хөгжлийг түүчээлэх чадвартай Монгол хүнийг хөгжүүлнэ.** | | | | | | | | | |
| 26 | 2.2.1 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “Мэргэжил сонголт” арга хэмжээг үе шаттай зохион байгуулж, гадаад, дотоодын их, дээд, ерөнхий боловсролын сургууль болон бусад боловсролын байгууллагуудтай олон талт хамтын | Улс, орон нутгийн төсөв | "Мэргэжил сонголт" арга хэмжээг зохион байгуулах сургалтын байгууллага | 2021 | 11 байгууллагатай хамтарч, 1600 суралцагчдыг хамруулна. | 12 байгууллагатай хамтарч, 1610 суралцагчдыг хамруулна. | “Мэргэжил сонголт” арга хэмжээг Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Их дээд сургуулиуд, ерөнхий боловсролын 34 сургууль 26 их дээд сургуулиудтай хамтран давхардсан тоогоор 38 арга хэмжээг цахимаар зохион байгуулж, 12-р ангийн 1265 /давхардсан тоогоор/ суралцагчид хамрагдлаа.<br>УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатын дэмжлэг, санаачилгаар жил бүр уламжлал болгон ерөнхий боловсролын сургуулийн төгсөх 12-р ангийн сурагчдад мэргэжил сонголт, их дээд сургуульд элсэх талаарх | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллагааг өргөжүүлэн ажиллана. | | | | | | зөвлөмж, гарын авлага "ШИНЭ АЛХАМ-2021" номыг давхцсан тоогоор 1265 сурагчдад түгээж, мэргэжлийн давуу болон сул тал, тухайн мэргэжлийг сонгохын ач холбогдол зэргийг таниуллаа. ОХУ-ын Бүгд найрамдах Буриадын Улстай хамтран ажиллах гэрээний хүрээнд Буриад улсын 7 их, дээд сургууль, коллежид 23 суралцагчид суралцах боломжтой боллоо. “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ?”, “Мэргэжил сонгоход нөлөөлдөг хүчин зүйлс” зэрэг олон төрлийн зөвлөмжийг 10-12-р ангийн 3277 суралцагчдад мэдээлэл технологийг ашиглан суралцагчдад түгээж байна. БҮТ-ийн http://help.eec.mn/ сайтаас суралцагчид мэдээллийг авч хэвшсэн. | |
| 27 | 2.2.2 | "Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээ хэрэгжүүлнэ. | Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр | “Сургалтын байгууллага-Тоног төхөөрөмж” арга хэмжээнд хамрагдаж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллага | 2021 | Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулж эхэлсэн. | “Сургалтын байгууллага- тоног төхөөрөмж” арга хэмжээнд 79 байгууллага хамрагдана. Шаардлагатай тоног төхөөрөмжийн 50 хувийг хангана. | “Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээний хүрээнд давхацсан тоогоор 34 сургууль, 18 цэцэрлэгт нийт 516,1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, гал тогооны тоног төхөөрөмжийг нийлүүлснээр сургуулийн 70 хувь, цэцэрлэгийн 80 хувийг гал тогооны тоног төхөөрөмжөөр хангалаа. | 70% |
| 28 | 2.2.3 | “Чадварлаг багш” арга хэмжээг зохион байгуулна. | Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр | Багш бүрийг хөгжүүлэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдсан багш | | 6910 багш хамрагдсан, Тэргүүн туршлагын цахим сан үүсгэсэн Зөвлөх | 6950 багш хамрагдаж, тэргүүн туршлагын цахим сан үүсгэсэн Зөвлөх багш, Тэргүүлэх | Цахим платформд суурилан зохион байгуулагдаж буй багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих модуль сургалт “Aplus платформ” дээр зохион байгуулагдаж, мэргэжлийн багш нар өөрсдийн хэрэгцээнд үндэслэн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2021 | багш, Тэргүүлэх зэрэгтэй 10 багш | зэрэгтэй 15 багш | “Багшийн мэргэшлийн хөгжлийг дэмжих, СӨБ болон ЕБС-ийн 14 судлагдахууны хөтөлбөрийн модуль-83, “Удирдах ажилтны хөгжлийг дэмжих сургалтын модуль-7, “Багш, ажилтны мэргэжлийн болон хувь хүний хөгжлийг дэмжих сургалтын модуль” 20 сэдвээр давхардсан тоогоор СӨБ-ын 301, ЕБ-ын 1134 багш сонгон сургалтад хамрагдлаа. Үндэсний үндсэн сургалтад 134 багш, 29 ажилтан, орон нутгийн сургалтад 1210 багш, цахим сургалтад 2890 багш хамрагдаж, мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн. | 100% |
| 29 | 2.2.4 | Судалгаа, арга зүйн байгууллагуудтай хамтран сургууль, цэцэрлэгийн сургалтын чанарыг сайжруулна. | Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр | Сургалтын чанарын үнэлгээ Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн зөвлөн туслах үйлчилгээ, захиалгат сургалт авсан байгууллага | 2021 | Чанарын үнэлгээ<br>• Бага-52.5%<br>• Суурь-35.9%<br>• Бүрэн дунд-36.8%-д хүргэнэ, 7 байгууллага хамрагдсан. | Чанарын үнэлгээ<br>• Бага-53.0%<br>Суурь-36.4%<br>• Бүрэн дунд-37.3%-д хүргэнэ. 10 байгууллага хамрагдана. | Боловсролын үнэлгээний төвөөс батлагдсан удирдамжийн дагуу 7 сургуулийн 580 сурагч чанарын үнэлгээний шалгалтад хамрагдсан. Оношлох үнэлгээгээр улсын дундаж /40.46/-аас 1.02 хувиар дээгүүр, элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж өнгөрсөн жил /503.7/-ийнхээс 2.9 хувь ахисан. Боловсролын олон улсын үнэлгээний “PISA-2022”-шалгалтад 7 сургууль сонгогдон цахим шалгалтад Сүхбаатар сумын 4, 6, Шаамар, Баянгол, Бугант, Мандал-2, Мандал-5 дугаар сургуулийн 9-11-р ангийн 192 сурагчид хамрагдсан. БШУЯ, БЕГ, БСҮХ-ээс зохион байгуулж байгаа “Үндэсний хоцрогдол арилгах хөтөлбөр”-ийн хүрээнд suraad.mn системийг ашиглаж ЕБС-ийн сурагчдын түвшинг тогтоон, сурагчдыг хоцрогдлоос гаргах, түвшин ахиулах, зөвлөгөө авах цахим сургалтад Сайхан сумын 1, Сүхбаатар сумын 5 дугаар сургуулийн 6-12-р ангийн 319 суралцагчид хамрагдсан. Энэ | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хөтөлбөрийн хүрээнд “Suraad.mn” цахим онлайн сургалтын системийг ашиглах арга зүйн сургалтад дээрх 2 сургуулийн математикийн 6 багш хамрагдан суралцагч, эцэг эхчүүдтэй хамтран ажиллаж байна. Багшийн хөгжлийг дэмжих модуль сургалт “Aplus” платформ дээр өөрсдийн хэрэгцээнд үндэслэн “Багшийн мэргэшлийн хөгжлийг дэмжих, СӨБ болон ЕБС-ийн 14 судлагдахууны хөтөлбөрийн 83 модуль, удирдах ажилтны хөгжлийг дэмжих сургалтын 7 модуль, багш, ажилтны мэргэжлийн болон хувь хүний хөгжлийг дэмжих сургалтын 20 модуль сургалтад давхардсан тоогоор сургуулийн өмнөх боловсролын 43 байгууллагын 301, Ерөнхий боловсролын 35 сургуулийн 1134 багш сонгон сургалтад хамрагдлаа. | |
| 30 | 2.2.5 | Хүүхэд бүрийн авьяас, чадварыг нээн илрүүлж, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх “Хүүхэд хөгжлийн ордон” байгуулна. | 2181680.37 9 төгрөг | Хүүхэд хөгжлийн ордоны барилгын гүйцэтгэл Дугуйлан, сонгон, секцэд хамрагдсан хүүхдүүд | 2021 | 9100 хүүхдүүд хамрагдан, Хүүхэд хөгжлийн ордоны барилгын гүйцэтгэл-90 хувьтай. | 9200 хүүхдүүд хамрагдан, хүүхэд хөгжлийн ордон ашиглалтад орно. | Аймгийн ерөнхий боловсролын 35 сургуульд дүрслэх урлаг, дизайн технологийн чиглэлээр 18 төрлийн секц дугуйланд 1765, биеийн тамир, эрүүл мэндийн чиглэлээр 17 төрлийн секц дугуйланд 3397, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх чиглэлээр 67 нэр төрлийн секц дугуйланд 3650 нийт 8812 суралцагч секц, дугуйланд хамрагдаж, 505 багш,14 иргэн гэрээгээр ажиллаж, сургуулийн орчинд хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааг чиглүүлэн ажиллаж байна.<br>Улсын төсвийн 2.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4-р багт баригдаж байгаа “Хүүхэд хамгаалал, хөгжлийн төв”-ийн барилгын гүйцэтгэгчээр “Бүрэн одод” ХХК шалгаран гүйцэтгэж байна. Гүйцэтгэл | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 80 хувьтай байна. | |
| 31 | 2.2.6 | Тусгай хэрэгцээт хүүхдийг сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлнэ. | Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр | Тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан жишиг танхимтай болсон сургууль, цэцэрлэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч сувилах, сургах цэцэрлэг Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа | 2021 | .1 сургууль, 1 цэцэрлэгт жишиг танхимтай болгоно.<br>5 удаагийн сургалт, нөлөөлийн үйл ажиллагааг зохион байгуулна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч сувилах, сургах цэцэрлэгийг засварлана | 1 сургууль, 1 цэцэрлэгт жишиг танхимтай болгоно.<br>7 удаагийн сургалт, нөлөөлийн үйл ажиллагааг зохион байгуулна.<br>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч сувилах, сургах цэцэрлэгийг засварлана. | ДЗМОУБ-ын дэмжлэгтэйгээр Сүхбаатар сумын 3-р сургуульд жишиг танхимыг бий болгож, аймгийн төсвийн 206.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сувиллын зориулалтаар цэцэрлэгийн барилгыг иж бүрэн засварлаж, Сүхбаатар сумын 6-р цэцэрлэгийг байршуулж, 53 хүүхдийг сувилж байна.<br><br>“Хөгжлийн бэршээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус өмчийн 22 цэцэрлэгт хүмүүжиж байгаа 36 хүүхэд, ерөнхий боловсролын 29 сургуульд суралцаж байгаа 132 хүүхдийн эцэг эхчүүдэд ганцаарчлан ажиллах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах арга зүйн нөлөөлөл сургалтын ажлыг тогтмол хийж хэвшсэн. Японы Тоёо их сургуулийн “Хүний хөгжлийн судалгааны хүрээлэн”-гээс зохион байгуулсан тэгш хамран сургах арга зүйн 3 удаагийн сургалтад 30 багшийг эцэг эхчүүдийн хамт хамрууллаа.<br><br>Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран зохион байгуулсан “Дохионы хэлний” анхан шатны сургалтад багш нараа хамрууллаа. | 100% |
| 32 | 2.2.7 | Ерөнхий боловсролын лаборатори 4 дүгээр, Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль | Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр | Шинээр баригдсан, их засвар хийгдсэн сургууль, цэцэрлэг, спорт заал | | 2 сургуулийг өргөтгөх, 1 сургууль, 1 цэцэрлэг шинээр барих зураг төсөв хийх, "Тарни", "Билиг" | 2 сургуулийг өргөтгөх, 1 сургууль, 1 цэцэрлэг шинээр барих ажлыг эхлүүлнэ.<br>12 цэцэрлэг, 11 | Ерөнхий боловсролын лаборатори 4 дүгээр сургууль, Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийн ажил гүйцэтгэх компанитай гэрээ цуцлагдсан. Сүхбаатар сумын 4 дүгээр багт 200 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | болон Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулиудын хичээлийн байрны өргөтгөл, зарим шаардлагатай сургуулийн спорт заалыг шинээр барих, сургууль, цэцэрлэгүүдийн их засварын ажлыг ээлж дараатай шийдвэрлэнэ. | | | 2021 | ДБ сургуулиудыг спорт заалтай болгох ажлыг эхлүүлж, 5 цэцэрлэг 5 сургуульд их засвар хийсэн. | сургуульд их засвар хийнэ. | хүүхдийн цэцэрлэг, Цагааннуур суманд 320 хүүхдийн суудалтай хичээлийн барилгын ажил эхэлж, Ерөө сумын 200 ортой цэцэрлэгийн барилгыг ашиглалтад хүлээн авлаа. Орон нутгийн 190.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2 сургууль /Мандал-4, Алтанбулаг/-ийн дээврийг засварлаж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжүүлсэн Сүхбаатар сумын 3, Сайхан сумын 3, Мандал сумын 1 дүгээр цэцэрлэгүүдийн их засварын 1.012.6 сая төгрөгийн өртөгт ажил хэрэгжиж дуусаагүй байгаа бөгөөд үнийн өсөлттэй холбогдуулан гүйцэтгэгч компаниуд нь Барилга хөгжлийн газар болон БШУЯ-нд хүсэлтээ хүргүүлээд байна. Сүхбаатар сумын Засаг даргын нөөцөөс 16.0 сая төгрөгөөр 2 дугаар цэцэрлэгийн дээврийн засварын ажлыг шийдвэрлэсэн.2021-2022 онд улс болон аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5 сургууль, 1 дотуур байр, 2 цэцэрлэгийн барилгын их засвар хийгдэж, 1 сургууль, 2 цэцэрлэгийн барилгын их засвар он дамжин хийгдэж байна. | 50% |
| 33 | 2.2.8 | Ерөө суманд 960 хүүхдийн сургууль, Мандал суманд 100 хүүхдийн цэцэрлэг, Түнхэл тосгонд 50 хүүхдийн дотуур байрыг ашиглалтад оруулна. | Улсын төсөв | Шинээр баригдсан сургууль, цэцэрлэг, дотуур байр | 2021 | 1 сургуулийн өргөтгөл-0, 1 сургуулийн өргөтгөл-27 хувьтай, шинэ 1 цэцэрлэг-90%, 1 цэцэрлэг-80%, 1 цэцэрлэгийн барилгын өргөтгөл-80%-тай. | 2 сургуулийн өргөтгөл, 2 цэцэрлэг ашиглалтад оруулах, шинээр АББ нэгжийн 1 барилга, 1 сургуулийн өргөтгөл, 1 цэцэрлэг шинээр барих, 1 сургуулийн | Ерөө суманд Олон улсын стандартад нийцсэн 960 хүүхдийн багтаамжтай эко сургуулийг “Монголын Алт” компани нийгмийн хариуцлагын хүрээнд 11,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулан хүлээлгэн өгсөн нь төр хувийн хэвшлийн хамтарсан нэг том бүтээн байгуулалт болсон. Мандал суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын дутуу ажлыг гүйцэтгэх 771.2 сая төгрөгийг улсын төсөвт 2018 онд тусгуулж, хариуцагч | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | барилга худалдан авна. | “Талын Монгол” групп ХХК-д ажил эхлүүлэх чиглэл хүргүүлсэн боловч, энэ ажил 8 жил удааширсны улмаас шүүхэд хандаад байна. Орхонтуул сумын Рашаант тосгоны 75 ортой цэцэрлэгийн барилгын гүйцэтгэл 90 хувьтай байна. Түшиг сумын цэцэрлэг Баруунбүрэн сумын Насан туршийн боловсролын төвийн байр барих тендер зарлагдсан байна. Түнхэл тосгонд 50 хүүхдийн дотуур байрны зураг төсвийг 75 болгон өөрчилж, зураг төсвийг “MSL” ХХК-иар хийлгүүлж, газрын асуудлыг шийдвэрлэсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Мандал суманд 480 суудалтай ерөнхий боловсролын сургуулийг төрд худалдаж авлаа. | |
| 34 | 2.2.9 | Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехникийн коллежийг дэмжиж, орон нутгийн онцлог давуу талд түшиглэн мэргэжлийн төрлийг нэмэгдүүлнэ. | Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр | Сургалтад хамрагдсан коллеж, МСҮТ-ийн багш нар | 2021 | 16 багш нарыг мэргэжил, арга зүйн сургалтад хамруулж, 112 төрлөөр мэргэжил эзэмшүүлэх сургалт явуулна. | 16 багш нарыг мэргэжил, арга зүйн сургалтад хамруулж, 13 төрлөөр мэргэжил эзэмшүүлэх сургалт явуулна. | Ерөнхий эрдмийн 19 багшийг мэргэжил, арга зүйн сургалтад, бүсийн арга зүйн сургалтын төвд багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтад 120 багш, ажилтныг хамруулсан.<br>Сэлэнгэ МСҮТ-д 8 мэргэжлээр 236 оюутан, Шаамар МСҮТ-д 6 мэргэжлээр 131 оюутан, “Зүүнхараа” политехник коллежид 12 мэргэжлээр 279 оюутан суралцаж, нийт 19 мэргэжлээр 646 оюутан сурч байгаагаас:<br>• шинээр элссэн нийт суралцагч 406,<br>• 2-3 курсын суралцагч 240,<br>• малчин өрхийн нийт 78 суралцагч, үүнээс шинээр элссэн 28,<br>• хөгжлийн бэрхшээлтэй | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нийт 10 суралцагч, үүнээс шинээр элссэн 7,<br>• дотуур байранд суралцагч 137 /эрэгтэй 95, эмэгтэй 42/ байна.<br>2021 онд мэргэжлийн 25 төрөл байсан бол 2022 онд мэргэжлийн шинэ ангийг нэмж, нийт 26 төрлөөр оюутнууд элсүүлэн сургаж байна. “Зүүнхараа” политехник коллежийн бэлтгэх мэргэжлийн чиглэл нь 50-иас дээш хувийг техникийн боловсрол эзэмшүүлэх сургалт давамгайлж байгаа бол Мэргэжлийн боловсрол, сургалтын 2 байгууллагыг эдийн засгийн бүс, газар нутгийн байршлаасаа хамаарч зонхилох мэргэжлийн чиглэлээр төрөлжүүлэх бодлого баримтлан ажиллаж байна. | |
| 35 | 2.2.10 | Хүүхэд, залуучуудын орос хэл сурах идэвхийг өрнүүлж, “Оросын шинжлэх ухаан, соёлын төв”-ийн салбарыг нээн ажиллуулна. | Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр | “Оросын шинжлэх ухаан, соёлын төв” нээгдсэн эсэх, Мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдсан орос хэлний багш, “Ялалтын баяр”-ыг тохиолдуулан ард иргэд, сурагчдад зориулсан арга хэмжээ | 2021 | Оросын Шинжлэх Ухаан Соёлын төвтэй хамтран Сүхбаатар сумын 3-р сургуулийг түшиглэн 2019 онд Орос хэлний “Эгсүн” төв шинээр байгуулсан боловч үйл ажиллагаа зогссон. Сургалтад 2 багш хамрагдсан. | Салбарыг нээж, үйл ажиллагааг эхлүүлнэ. Сургалтад 14 багш хамруулна. “Ялалтын баяр”-ыг тохиолдуулан ард иргэд, сурагчдад зориулсан 1 арга хэмжээ | ОХУ-ын Буриадын Бүгд найрамдах улсын Боловсрол, шинжлэх ухааны яамны төлөөлөлтэй 2 удаагийн ажил, хэргийн уулзалтыг хийж, аймгийн ерөнхий боловсролын лаборатори 4 дүгээр сургуулийг түшиглэн орос хэл сурахад зориулсан иж бүрэн кабинет байгуулах, Сүхбаатар сумын ЕБ-ын 1 дүгээр сургууль дээр Орос хэлний төвийг нээн Оросын шинжлэх ухаан, соёлын төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулж 1636 ам.д үнэ бүхий багш, сурагчийн гарын авлагаар хангалаа. Улаанбаатар хот дахь Оросын соёл, шинжлэх ухааны төв "Русский Дом" байгууллагаас багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих зорилгын хүрээнд 2022 оны 11-р сарын 5,6-ны өдрүүдэд Орос хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж, нийт 19 багш хамрагдаж, мэргэжил арга зүйгээ | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дээшлүүлэв. Буриадын их сургуулийн тэтгэлэгт улсын уралдаанд Орхонтуул сумын ЕБС-ийн 12-р ангийн сурагч Сэлэнгэ лаборатори 4 дүгээр сургуулийн орос хэлний багш нар тэнцлээ. “Ялалтын баяр”-ыг тохиолдуулан Сайхан сумын 1 дүгээр сургуулийн 7-9 -р ангийн сурагчид, багш нарын дунд орос хэлний хичээлийн хүрээнд “Алтан хонх” тэмцээнийг зохион байгууллаа. | |
| 36 | 2.2.11 | Сургууль бүр сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | Улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр | Сэтгэл зүйч ажиллуулсан сургууль, сэтгэл зүйн зөвлөгөө авсан багш, сурагчид, эцэг | 2021 | 1 сургууль сэтгэл зүйч ажиллуулж, Сэтгэл зүйн зөвлөгөө авсан 310 багш, 652 сурагчид, 361 эцэг эх | 7 сургууль сэтгэл зүйч ажиллуулна. Сэтгэл зүйн зөвлөгөө авсан 315 багш, 660 сурагчид, 351 эцэг эх | Ерөнхий боловсролын 8 сургуульд сэтгэл зүйч ажиллуулж, 1066 хүүхэд, 285 эцэг эх, асран хамгаалагч, 187 багш ажилтанд мэргэжлийн сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлсэн. | 90% |
| **2.3.Биеийн тамир, спорт** | | | | | | | | | |
| **Биеийн тамир, спортыг дэмжих замаар хүний дундаж наслалтыг уртасгана.** | | | | | | | | | |
| 37 | 2.3.1. | “Спортлог Сэлэнгэчүүд” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Улс орон нутгийн төсөв | Хичээллэж байгаа секц сургалт, хамрагдсан хүүхэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хэрэглэлээр тоноглолтой зал Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон төрөлт тэмцээн | 2021 | 172 секц 2870 хүүхэд 1 арга хэмжээ | 174 секцэд, 3200 хүүхэд хамруулна. 3 заалтай болно, 1 арга хэмжээ зохион байгуулна. | Спортын 173 төрлийн секц дугуйланд давхардсан тоогоор 3400 хүүхэд хичээллэж өсвөрийн шилдэг тамирчин бэлтгэж зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. 2022 оны байдлаар жудо, бокс, таеквондо, волейбол, хүндийн өргөлт зэрэг спортын төрлөөр өсвөрийн 5 тамирчин улсын шигшээ багт шалгарсан. Боксын ОУХМастер О.Есүгэн Хойд номхон далайн бүсийн орнуудын аварга, Азийн тивийн аваргын хүрэл медаль, жудо бөхийн ОУХМастер Л.Энхрийлэн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медалийг тус тус хүртлээ. ХААН банкны хөрөнгө оруулалтаар Сүхбаатар сум, Мандал суманд 3х3 сагсан бөмбөгийн стандартын талбайг | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | барьж ашиглалтад оруулсан. Сайхан, Баянгол, Цагааннуур, Ерөө спортын цогцолборууд, Спортын ордоны ашиглалтыг сайжруулах чиглэлээр урсгал засварын ажлыг 730.0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бүрэн хийлээ. Спортын 8 цогцолборын орчин нөхцөл, спортын хэрэглэл материалын хүрэлцээг нэмэгдүүлэхэд 4.0 сая төгрөгийг зарцууллаа. Мандал суманд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн суугаа волейболын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 5 багийн 40 гаруй иргэдийг хамруулан улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох багийг сонголоо. Монголын бүх ард 15 дугаар наадамд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл оролцож, 2 алт 1 мөнгө 2 хүрэл медаль хүртлээ. | |
| 38 | 2.3.2. | “Эрүүл иргэний төлөө хамтдаа” хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж, үр дүнг тооцно. | Улс орон нутгийн төсөв | Иог, бясалгал, нийтийн бүжиг, бялдаржуулах спортоор хичээллэсэн иргэд, Зохион байгуулсан "Сэлэнгэ марафон" арга хэмжээ | 2021 | 1 арга хэмжээ | 100 иргэд хичээллэнэ.<br>1 арга хэмжээ зохион байгуулна. | Аймгийн хэмжээнд нийт 42 төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 72 арга хэмжээг зохион байгууллаа. Эрүүл иргэний төлөө, дархлаагаа дэмжиж чиглэлээр “Иргэдийн наадам”, “Эрүүл иргэн-эртэч Монгол аян”, аймгийн хэмжээнд “Жингийн илүүдэлгүй- эртэч Сэлэнгэчүүд” аян, Ахмадын баярыг угтсан арга хэмжээний аян, Цасны баяр, бүх нийтийн гүйлт, өдөрлөг, нэрэмжит тэмцээн, өртөөт марафон, аялал, аян зэрэг олон төрлөөр үйл ажиллагааг явуулж 14 зорилтот арга хэмжээнүүдэд 11200,000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж аймгийн хэмжээний 70448 хүнийг татан оролцууллаа. Монгол орон даяар зохион байгуулсан “Эрүүл мэндийн цахим гүйлт-2021”, “4 аймаг 400 км” | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үзэл санааны явган алхалт арга хэмжээнд 480 гаруй иргэн хамрагдаж нийт 4000 гаруй км замыг туулсан бол монголын тамирчидаа алдаршуулах, Ардын хувьсгалын өлгий Сэлэнгэ-100мкм 3 өдөр, 2 шөнийн явган алхалтыг аймагтаа амжилттай зохион байгууллаа. “Сэлэнгэ марафон 2022” улсын аварга шалгаруулах тэмцээнийг 4 насны ангилаар зохион байгуулж, 14 сум, Улаанбаатар хотын 7 дүүрэг, 10 аймгийн ахмад, өсвөрийн 560 гаруй тамирчид оролцлоо. | |
| 39 | 2.3.3. | Аймгийн Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын дунд спортын олон төрөлт тэмцээнийг жил бүр зохион байгуулна. | Улс орон нутгийн төсөв | Аймаг, сумын төрийн байгууллагуудын дунд зохион байгуулсан олон төрөлт арга хэмжээ | 2021 | 1 арга хэмжээ зохион байгуулсан. | 1 арга хэмжээ зохион байгуулна. | Аймгийн Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын тэмцээнийг шинээр усан спортын төрлийг нэмж, спортын 7 төрлөөр зохион байгуулж, 700 гаруй албан хаагчид оролцон Хилийн цэргийн 0101 ангийн баг тэргүүллээ.<br>Ерөө, Цагааннуур, Жавхлант сумдын Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын тэмцээнүүдийг спортын 2-5төрлөөр зохион байгуулж, нийт 90 гаруй албан хаагчид, Сайхан бүсэд төрийн албан хаагчдын дундах тэмцээнийг 4 төрлөөр зохион байгуулж, 110 гаруй албан хаагчид оролцсон бол аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төрийн албан хаагчдын дунд спортын олон төрөлт тэмцээнийг 17 сумдын дунд спортын 4 төрлөөр зохион байгуулж 110 гаруй төрийн албан хаагчид хамрагдлаа. | 100% |
| 40 | 2.3.4. | Усан спортоор хүүхэд, залуус, иргэдийг хичээллэх боломжоор хангаан усан сэлэлтийн тэмцээнийг жил | Улс орон нутгийн төсөв | лабораторийн тоног төхөөрөмжөөр хангалт, Аймгийн усан спортын аварга шалгаруулах арга | 2021 | 1 лаборатори ажиллаж байна. Аймгийн аварга шалгаруулах 1 арга хэмжээг зохион байгуулсан. | 3 төрлийн тоног төхөөрөмжөөр хангаж, 1 арга хэмжээ зохион байгуулна. | Усан спортын төвд 3 төрлийн тоног төхөөрөмжөөр хангуулахаар төсөв саналаа дээд шатанд уламжлаад байна. Усан спортын улсын аварга шалгаруулах тэмцээнд 10 тамирчинг оролцуулан 3 тамирчин улсын 2-р зэргийн норм биелүүлэн, 1 тамирчин | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүр зохион байгуулна. | | хэмжээ | | | | алтан медаль хүртсэн амжилтыг үзүүлсэн. Усан спорт сонирхогчдын дунд “Би сэлж сурсан” усан спортын аварга шалгаруулах тэмцээнийг 3 удаа зохион байгуулж, 130 гаруй тамирчдыг хамрууллаа. Төрийн албан хаагчдын тэмцээнд усан спортын төрлийг нэмж оруулснаар энэ төрлөөр хичээллэх албан хаагчдын тоо нэмэгдлээ. Усан спортоор нийт 4272 хүнд үйлчилгээг үзүүлсэн. | |
| 41 | 2.3.5 | “Хүүхдийн олимп” наадмыг зохион байгуулна | Улс орон нутгийн төсөв | Зохион байгуулсан арга хэмжээ | **2021** | **-** | 1 арга хэмжээ зохион байгуулна. | Хүүхдийн олимпын спортын сонгон шалгаруулалтад ширээний теннис, шатар, даам, жудо бөх, чөлөөт бөх, сагсан бөмбөг, жюу жи цү спортын төрөлд өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн 9 тэмцээнд оролцож, 39 медаль хүртсэн. МБАТНаадам, ҮСНаадам зэрэг спортын үйл ажиллагаанд 3498 тамирчид оролцож улсын 30 тэмцээнээс 46 алт, 57 мөнгө, 50 хүрэл медаль хүртсэн байна. | 100% |
| 42 | 2.3.6 | Биеийн тамир, спортын салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхжуулах, мерит зарчмын дагуу шат шатны байгууллагуудад шатлан ажиллуулах бодлого хэрэгжүүлнэ. | Улс орон нутгийн төсөв | Сургалтад хамрагдсан, сэлгэн ажилласан биеийн тамирын багш дасгалжуулагч-дын тоо | 2021 | Мэргэшүүлэх сургалтад 20 хувь нь хамрагдсан. 1 багш туршлага судалсан. | Мэргэшүүлэх сургалтад 50 хувь нь хамруулна.<br>4 багшийг туршлага судлуулна. | Мэргэжил, сургалт дасгалжуулалт, мэдлэг чадвар олгох 69 сургалтад 100 хувь багш, ажилчид хамрагдсан. Мэргэжлийн багш нарыг спортын чиглэлийн дагуу сумдад ажиллуулан хоорондын туршлагаа солилцож хамтарсан бэлтгэл хангуулан ажиллаж байна. Чөлөөт бөхийн дасгалжуулагч багшийг Дархан-Уул аймагт 14 хоног туршлага судлуулах, мөн Буриад улсад 21 хоногийн сургалт, хамтарсан бэлтгэлд оролцуулсан. Бокс, жудогийн төрлөөр сумдаас элсэлт авах чиглэлээр 7-14 хоног сургалтыг зохион байгууллаа. | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 43 | 2.3.7 | Үндэсний спортын төрлөөр хичээллэгсэд болон сонирхогчдын тоог нэмэгдүүлж, хүүхэд залуучуудад өвлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. | Улс орон нутгийн төсөв | Үндэсний спортын төрлүүдээр зохион байгуулсан сургалт, Зохион байгуулсан үндэсний спортын арга хэмжээ | 2021 | Үндэсний спортын 4 төрлөөр 4 тэмцээн зохион байгуулсан. | 1 удаа зохион байгуулна. Үндэсний спортын 4 тэмцээн зохион байгуулна. | Үндэсний бөхийн төрлөөр Сүхбаатар, Алтанбулаг, Баянгол, Ерөө, Мандал сумдад тус бүр 1 секц хичээллэж, 134 хүүхэд, үндэсний сурын харвааны төрлөөр Хүдэр, Ерөө, Орхон сумд, Дулаанхан тосгонд 91 хүүхэд, шагайн харваан төрөлд 34 хүүхэд хичээллэж байна.<br>Үндэсний спортын төрөл шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2 жилд 4 удаа зохион байгуулан уг тэмцээнүүдэд 17 сумын багийн 450 гаруй тамирчид оролцлоо. Шагайн спортын төрлөөр үлэмж дархан мэргэн 1 төрөн гарсан. Үндэсний сурын халх харваа, буриад харваа, уламжлалт харваа, урианхай сурын аймгийн аварга шалгаруулах тэмцээнүүдийг 6 удаа 3 суманд зохион байгуулж, 250 гаруй харваачид уралдсан байна. Мөсөн сурын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг анх удаа зохион байгуулж, 17 сумд, 6 тосгодын 40 гаруй тамирчид оролцлоо. Үндэсний бөхийн барилдааныг өсвөр, насанд хүрэгчдийн дунд 3 удаа зохион байгуулан 210 гаруй бөхчүүдийг хамрууллаа. | 100% |
| 44 | 2.3.8 | Тамирчдын ур чадварыг ахиулж, улс, тив, дэлхийд өрсөлдөхүйц тамирчдыг бэлтгэнэ. | Улс орон нутгийн төсөв | Тамирчин, дасгалжуулагч-дын нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулах | **2021** | COVID-19) цар тахалын улмаас санхүүгийн дэмжлэг үзүүлээгүй | Санхүүгийн дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас үзүүлсэн. | Аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа клуб, холбоодтой хамтран ажиллаж шаардлагатай 57,550,000 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас 134 тамирчдад үзүүлснээр баг тамирчид улсын аварга шалгаруулах 7 тэмцээнд тэргүүлж, тив дэлхийн болон олон улсын хэмжээний | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | тэмцээнүүдэд шатар, бокс, жү-до, чөлөөт бөхийн тэмцээнээс алт, мөнгө, хүрэл медаль хүртсэн амжилтуудыг үзүүллээ. | |
| 45 | 2.3.9 | Иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулна. | Улс орон нутгийн төсөв | Ашиглалтад орсон хөл бөмбөгийн талбай, Спортын хэрэглэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан спорт цогцолбор | **2021** | **-** | Хөл бөмбөгийн талбайг байгуулах зураг төсвийг хийж, батлуулах, газрын асуудлыг шийдвэрлэх | Хөл бөмбөгийн талбай ашиглалтад оруулах газрыг судлан, зураг төсвийг шинээр боловсруулах ажлыг гүйцэтгэж байна. Спорт цогцолборуудад сагсан бөмбөг, волейболын тэмцээн явуулах иж бүрэн хэрэглэл, бялдаржуулах танхимд иж бүрэн 11 төрлийн тоноглол, шагайн харваан бүрэн хэрэглэлтэй болгосон. Алтанбулаг суманд спортын цогцолбор, Мандал суманд соёл, амралт, биеийн тамирын иж бүрэн талбайг ашиглалтад оруулж, Баянгол, Цагааннуур, Ерөө спортын цогцолборууд, Спортын ордоны ашиглалтыг сайжруулах чиглэлээр урсгал засварын ажлыг 730.0 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бүрэн хийлээ. Баянгол, Сайхан сумын спорт цогцолбор тоног төхөөрөмжөөр, Алтанбулаг сум, Дулаанхан тосгоны спорт цогцолборыг 2 ком, ширээ сандалаар хангалаа. | 50% |
| 46 | 2.3.10 | Хүүхэд, залуучуудын бие бялдрын хөгжлийг дэмжих зорилгоор заавал биелүүлэх спортын норм, нормативыг насны ангиллаар тогтоож мөрдүүлнэ. | Улс орон нутгийн төсөв | 6-17 насны бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох сорил | **2021** | **-** | 1 удаа авна | Ерөнхий боловсролын сургуулиудын хүүхдийн дунд бие бялдрын 5 чанарыг агуулсан заавал хийж гүйцэтгэх дасгал хөдөлгөөний нормативыг боловсруулж, секц сургалт бүрт ашиглан мөрдүүлэн ажиллаж байна. Мөн сургуулиудад бие бялдрын түвшин тогтоох сорилын программыг биеийн тамирын хичээлд оруулж өгснөөр хүүхдийн бие бялдрын хөгжлийг судалгаагаар илрүүлэх боломж бүрдсэн. Сорилд 6-64 насны 6024 иргэдийг хамруулж, нийт | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хүүхдийн 1,5 хувь хэт таргалалт, хөдөлгөөний хомсдолтой байна. | |
| 47 | 2.3.11 | Аймгийн Биеийн тамир, спортын газрыг түшиглэн бөхийн спортын нэгдсэн төвийг байгуулна. | Улс орон нутгийн төсөв | Ашиглалтад орсон чөлөөт бөх, самбо, жудо,үндэсний бөхийн спортын нэгдсэн заал | **2021** | **-** | 1 спорт зал ашиглалтад оруулна. | Аймгийн Биеийн тамир, спортын газрыг түшиглэн бөхийн спортын нэгдсэн төвийг байгуулахаар газрын асуудлыг шийдвэрлэн зураг төслийг боловсруулахаар ажиллаж байна. | 50% |
| 48 | 2.3.12 | Өвлийн спортыг дэмжих, Ерөө сумын Бугант тосгоныг түшиглэн хоккейн төслийг хөгжүүлнэ. | Улс, аймгийн төсөв | Хоккейн спортоор хичээллэгсэд | 2021 | Хоккейн спортоор 120 хүүхэд залуучууд хичээллэж байна. | Хоккейн спортоор 200 хүүхэд залуучууд хичээллэнэ. | Улсын аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдыг бэлтгэн оролцуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлснээр өсвөрийн тамирчид Улсын аварга болсон. | 70% |
| **2.4.Соёл, урлаг** | | | | | | | | | |
| **Хүний хөгжилд соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлж, соёл уламжлалаа дээдэлдэг иргэн төлөвшүүлнэ.** | | | | | | | | | |
| 49 | 2.4.1 | Хүүхэд, залуучууд, уран бүтээлчдийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэн, улсын болон олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ. | Улс орон нутгийн төсөв | “Уралдаан тэмцээний түвшин, ангиллын дагуу дэмжлэг үзүүлэх тухай” батлагдсан журам, Чадавхжуулах, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан соёл, урлагийн ажилтны тоо, Урлагийн боловсрол олгох талаар зохион байгуулсан арга хэмжээ | 2021 | Соёл, урлагийн 30 ажилтныг чадавхжуулах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, соёл, урлагийн байгууллага сургалтын бүх шатны байгууллагатай хамтран урлагийн боловсрол олгох 2 арга хэмжээ зохион байгуулсан. | Соёл, урлагийн 50 ажилтныг чадавхжуулах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, соёл, урлагийн байгууллага сургалтын бүх шатны байгууллагатай хамтран урлагийн боловсрол олгох 3 арга хэмжээ зохион байгуулна. | Уралдаан тэмцээнд дэмжлэг үзүүлэх тухай журам”-г боловсруулж, хэлэлцүүлэх бэлтгэлийг хангаж байна. “Дээлтэй Монгол-2022” наадамд дээл урлаач, өвлөн уламжлагч, гоцлол бүжигчдийн улсын анхдугаар уралдаанд оролцсон 20 гаруй уран бүтээлчдэд дэмжлэг үзүүллээ. "ШИЛДЭГ БҮТЭЭЛ-ШИЛДЭГ УРАН БҮТЭЭЛЧ" төв, орон нутгийн мэргэжлийн чуулгуудын уралдаант наадамд Сэлэнгэ аймгийн Ардын дуу, бүжгийн “Сэлэнгийн долгио” чуулга, Дуу, бүжгийн “Мөнгөн хараа” чуулгад 20.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүллээ. “СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР”-ын үйл ажиллагааны хүрээнд нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хүүхэд багачууд, иргэдэд зориулсан соёл, урлагийн тэмцээн уралдаануудыг зохион байгууллаа. “Нүүдэлчин” Дэлхийн Соёлын Фестивальд аймгаа төлөөлөн оролцсон 61 өвлөн уламжлагч нарт аймгийн Засаг даргын 30.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Соёлын яам, Соёл, урлагийн их сургуулиас хамтран зохион байгуулсан сургалтад аймгийн 20 соёлын төвийн 141 албан хаагчид, хамрагдлаа. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7/4/10 сургалтуудад бүх албан хаагчид хамрагдлаа. Соёл Урлагийн Их Сургуульд мэргэжлийн урлагийн байгууллагын 5 уран бүтээлч, соёлын төвийн 9 ажилтан мэргэжил дээшлүүлэхээр суралцаж байна. | |
| 50 | 2.4.2 | “Бид Сэлэнгийн үр сад”, “Эв модны наадам”, “Монгол өв соёл-Монголын дархлаа,” “Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл” зэрэг томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулан өв соёлыг түгээн дэлгэрүүлнэ. | Улс орон нутгийн төсөв | Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдад зориулсан арга хэмжээ | 2021 | Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдад зориулсан 1 арга хэмжээ зохион байгуулсан. | Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдад зориулсан 2 арга хэмжээ зохион байгуулна. | Шинжлэх ухааны академийн түүх угсаатны зүйн хүрээлэн, Соёлын өвийн үндэсний төвтэй хамтарч соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах, хамгаалах олон нийтэд түгээн телевизийн контент, баримтат кино нэвтрүүлэг бэлтгэж, мэргэжлийн судалгаа шинжилгээний ажлын арга барил туршлагыг судлан ажиллалаа. “Монгол үндэстэн ястны хувцас”-ны үзүүлэх тоглолт, уртын дуу, морин хуур, хөөмий, бий биелгээ, уран нугаралт, Монгол цам, тоглоом наадгайн танин мэдэхүйн боловсрол олгох “Өв Соёл” тоглолт “Монгол төгсөшгүй, мөхөшгүй, мохошгүй” язгуур урлагийн нэгдсэн тоглолтыг “Өв-соёлын өргөө”-нд зохион байгуулж 600 гаруй иргэн, хүүхэд залуучуудад толилууллаа. Сүхбаатар | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сумын 4, Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгүүд орон нутгийн төсвийн 27.5 сая төгрөгийн хөрөнгөөр шинээр “Гэр өргөө”-г ашиглалтад нь оруулж, нүүдэлчин өв соёлоо хадгалж, уламжлалаа түгээн дэлгэрүүлэх сургалт, үйл ажиллагаа явуулах боломжтой болсон. | |
| 51 | 2.4.3 | “Сэлэнгэ соёл” үзэсгэлэн худалдааг зохион байгуулна. | Улс орон нутгийн төсөв | Соёлын үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан арга хэмжээ Олон улсын төсөл хөтөлбөрт хамрагдсан соёлын үйлдвэрлэл эрхлэгчид | 2021 | Соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийг судлан тогтоож, арга хэмжээнд оролцуулах, дэмжлэг үзүүлэх 1 арга хэмжээг зохион байгуулж, соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах, олон улсын төсөл хөтөлбөрт хамруулсан. | Соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийг судлан тогтоож, арга хэмжээнд оролцуулах, дэмжлэг үзүүлэх 2 арга хэмжээг зохион байгуулж, соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхжуулах, олон улсын 2 төсөл хөтөлбөрт хамруулсан. | 17 сумд, 6 тосгодын соёл, урлагийн байгууллагаар дамжуулан тухайн орон нутагт ажиллаж амьдардаг соёлын үйлдвэрлэл эрхлэгчдийн анхан шатны судалгаа явуулж арьс шир, даавуун эдлэлээр 1, мод, модон эдлэлээр 1, үндэсний бичиг болон уран зураг чиглэлээр 1, эсгий эдлэлээр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 5 хүнийг албан ёсоор бүртгэлжүүлж “Цагаан эсгийний баяр-2022”эвент арга хэмжээ, “Соёлын орон зай” өдөрлөг, “Нүүдэлчин-2022” Дэлхийн Соёлын Фестивальд амжилттай оролцлоо. Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, орон нутгийн онцлогт тулгуурласан соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгоход дэмжиж ажиллалаа. | 90% |
| 52 | 2.4.4 | Монгол өв соёлоо ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билиг авьяастнуудыг алдаршуулна. | Улс орон нутгийн төсөв | Түгээн дэлгэрүүлсэн өвлөн уламжлалын арга хэмжээ | 2021 | 2 арга хэмжээ | 3 арга хэмжээ | Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгаа зохион байгуулж 492 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдыг бүртгэл мэдээллийн сан, монгол өв програмд оруулсан. Соёл, урлагийн байгууллагуудад өвлөн уламжлагчдыг судлан нээж илрүүлэх, бүртгэлжүүлэх, үйл ажиллагааг дэмжин нийтэд түгээн дэлгэрүүлэх, тэдний оролцоог сайжруулж арга хэмжээнд татан оролцуулах зэрэгт арга зүйн зөвлөгөө | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | өгсөн бөгөөд албан ёсоор бүртгэлд хамруулсан өвлөн уламжлагчдыг батламжлах ажлыг хэрэгжүүлэхээр бэлтгэж байна. 300 гаруй соёлын биет бус өвлөн уламжлагчдыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлж, шавь сургалтыг аймгийн хэмжээнд 36 удаа зохион байгуулсан. Соёлын биет болон биет бус өвийг уламжлагч 61 хүнийг байгууллагын цахим хуудсаар олон нийтэд танилцуулж алдаршууллаа. | |
| 53 | 2.4.5. | “Монгол төгсөшгүй, мөхөшгүй, мохошгүй” язгуур урлагийн хамтлагуудын нэгдсэн тоглолтыг зохион байгуулна. | Улс орон нутгийн төсөв | Арга хэмжээ, дугуйлангийн тоо | 2021 | Язгуур урлагийн дугуйлангийн тоо /сум бүр/ - 0 | Ерөө, Сэлэнгэ бүсэд урлагийн наадам зохион байгуулах | Соёл, урлагийн байгууллагад язгуур урлагийн 13 дугуйлан хичээллэж, нийт 55 суралцагчид хамрагдаж байна. “Монгол төгсөшгүй, мөхөшгүй, мохошгүй” язгуур урлагийн нэгдсэн тоглолтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Монгол угсаатан ястны хувцасны үзүүлэх тоглолт, уртын дуу, морин хуур, хөөмий, бий биелгээний сургалт, уран нугаралт, Монгол цам, тоглоом наадгайн танин мэдэхүйн боловсрол олгох “Өв Соёл” арга хэмжээнүүдийг зохион байгуулж язгуур урлагийн нэгдсэн тоглолтыг “Өв-соёлын өргөө”-нд зохион байгуулж 600 гаруй иргэн, хүүхэд залуучуудад толилууллаа. | 100% |
| 54 | 2.4.6 | “Монгол хүүхэд–Монгол соёл” цахим концертын арга хэмжээг зохион байгуулна. | Улс орон нутгийн төсөв | Цахим концертын арга хэмжээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт, Зохион байгуулсан цахим концертын арга хэмжээ | 2021 | Цахим концертын арга хэмжээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн зардлыг шийдвэрлэх бэлтгэл ажлыг хангансан. | 2 байгууллага цахим концертын арга хэмжээнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаж, арга хэмжээг зохион байгуулна. | “Чандмань" циркийн жүжигчдийн тоглолт, СӨБ, ЕБС-ий суралцагчдын дунд цахим орчинд үндэсний хэл бичгийн хэрэглээний соёлыг сурталчлах аян, "Соёлын үйлчилгээ-таны дэргэд", Монгол хөөмий, уртын дууны сургалтад суралцагсдын дунд зохион байгуулагдсан “Монгол бахархал” гала тоглолт, “Цагаан эсгийн зан үйлийн үзүүлбэр тоглолт”, “Наурыз-2022”, “Буриад дууг хэн сайн дуулах вэ?” зэрэг хүүхэд, багачуудад | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зориулсан 70 гаруй цахим арга хэмжээг зохион байгууллаа. Цахимаар “Ишигхэн ба түүний найзууд” хүүхдийн жүжиг, “Нүүдэлчин” Дэлхийн Соёлын Фестивальд оролцсон урлагийн тоглолт зэрэг хүүхэд багачуудын дунд зохион байгуулсан 10 гаруй уралдаан, баримтжуулалт бичлэг, нэвтрүүлэг, контент, видео шторкыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан түгээн дэлгэрүүлж нийт 88100 иргэнд үйлчиллээ. | |
| 55 | 2.4.7 | ”Сэлэнгэ сайхан нутаг”-ийн байгалийн өвийг баримтжуулж, хамгаалан түгээн дэлгэрүүлнэ. | Улс орон нутгийн төсөв | Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрын улсын тооллого Байгалын өвийг сурталчилсан явган аялал | 2021 | - | Түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрын улсын тооллогод хамрагдана. 6 сумдад байгалын өвийг сурталчлах явган аялал зохион байгуулна. | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, нийт 3237 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрыг улсын RICH-4 программд шивж оруулан байгалийн өвийг баримтжуулж 1963 гэрээт харуулуудтай гурвалсан гэрээг шинэчлэн байгуулж, үүрэг хариуцлага, хараа хяналтыг нэмэгдүүллээ. “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд 17 сум 6 тосгоны соёлын төвийн орон нутаг судлах танхимаас сургуулийн өмнөх боловсролын 44, ерөнхий боловсролын 35 сургуулийн захиргаатай хамтран эх орны үзэсгэлэнт байгаль, түүхэн газраар хүүхэд багачуудыг аялуулах арга хэмжээг зохион байгууллаа. | 70% |
| 56 | 2.4.8 | “Цахим номын сангийн сан хөмрөгийн үйлчилгээ”-ний хэрэглээг нэмэгдүүлнэ. | Улс орон нутгийн төсөв | Номын сангуудад цахим үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт | 2021 | Номын сангуудад цахим үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зардлыг | 5 номын сангуудад цахим үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган, 5 номын | Соёлын өвийг дээдлэн сэргээцгээе” аяныг зохион байгуулж, Монгол баатарлаг туульс “Жангар”, “Эрийн сайн хан харангуй” туульсийг цувралаар 2787 иргэнд, ардын өв уламжлалыг сурталчлах, үлгэрээр хүүхдээ хүмүүжүүлэх арга зүйг эцэг эхчүүдэд уриалах зорилготой “Домог | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдвэрлэх бэлтгэл ажлыг ханган, цахим номын үйлчилгээг хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангасан. | санд цахим үйлчилгээг хэрэглээнд нэвтрүүлнэ. | хуучлах цаг" цахим уралдаан зохион байгуулж, 2423 иргэнд хүргэсэн. "Монголын нууц товчоо" бүтээлийг 282 хоногийн турш цуврал болгон цахимаар хүргэж, "Монголын нууц товчоо"-той хамт Селфи аяныг зарлаж төр, хувийн хэвшлийн 12 байгууллага, 10,000 гаруй иргэдийг хамрууллаа. "Ном уншигч-Подкаст" ярилцлагыг "Үндэсний бичиг соёлын өдөр", "Агуу зүйл энгийнээс эхэлдэг", "Тогтмол явган алхалт хийх нь хүний эрүүл амьдрах үндэс юм" сэдвээр зохион байгуулж, монгол уйгаржин бичгийн апликейшн, Номын сангийн уншлага, үйлчилгээ, эрүүл амьдралын хэв маягийн тухай зөвлөмжийг бэлтгэн 314 уншигчдад хүргэлээ. Цахим номын санд шилжихтэй холбоотой шаардлагатай төсвийн саналыг 2023 оны төсөвт тусгуулахаар хүргүүлсэн. Соёл, урлагийн байгууллагуудын номын сангийн цахим үйлчилгээг сайжруулах техник тоног төхөөрөмжийн судалгааг гаргаад байна. | |
| 57 | 2.4.9 | Аймгийн Музей болон орон нутгийн судлах танхимд эх орныхоо түүх соёлыг таниулах зорилгоор хүүхдийн нас, сэтгэхүйд тохирсон үзмэрүүдээр баяжуулж, виртуал хэлбэрээр үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. | Улс орон нутгийн төсөв | Нэгдсэн музей болон сумдын орон нутаг сурталчлах танхимд зориулан иргэдээс худалдан авсан үзмэр | 2021 | 2 үзмэр | Аймгийн Нэгдсэн Музей 3 үзмэр, 5 ОНСТанхимыг виртуал хэлбэрт оруулж олны хүртээл болгоно. | Музейн сан хөмрөг баяжуулах ажлын хүрээнд Сэлэнгэ танхимд Шаамар сумын иргэн Д.Саруул өөрийн багш С.Баатарсайхан нар зөгийг Монголд нутагшуулах, бал гаргаж авах тухай брэнд бүтээгдэхүүнийг сурталчлах самбар, болон шилэн хорго 2 ширхэг хийлгэн, 44 ширхэг үзмэр эд өлгийн цуглуулга хандиваар авах ажлыг зохион байгууллаа.<br>Музейд шинээр авсан 41 дэсийн 44 ширхэг үзмэрийг RCH, Register программуудад бүртгэн баримтжуулж, сан хөмрөгөөс түр хугацаагаар "СЭЛЭНГЭ САЙХАН НУТАГ" | 50% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үзэсгэлэнд гарсан 25 дэсийн 32 ширхэг үзмэрийн бүртгэл судалгааг бүрэн хийж баримтжууллаа. Аймгийн Нэгдсэн Музейн үзмэрийг виртуал хэлбэрт оруулах төсөл гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зураг төсвийг боловсруулж байна. | |
| **2.5. Хүүхэд, залуучууд, гэр бүлийн бодлого** | | | | | | | | | |
| **Гэр бүл, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжиж, иргэн бүрт хүрсэн шуурхай үйлчилгээг бий болгоно.** | | | | | | | | | |
| 58 | 2.5.1 | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулж, “Хүчирхийлэлгүй аймаг” болох бодлогыг хэрэгжүүлнэ. | Улсын болон орон нутгийн төсөв | Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах чиглэлээр аж ахуй нэгж байгууллагад зохион байгуулсан нөлөөллийн ажил, Гэр бүлийн боловсрол олгосон сургалт, түүнд хамрагсад | 2021 | 5 сургалт зохион байгуулж 597 иргэнд гэр бүлийн боловсрол олгосон. 2 удаагийн сургалтад 40 иргэн хамруулсан. | 4 арга хэмжээнд 20 аж ахуйн нэгжийг хамруулна. 9 сургалтад 800 иргэнийг хамруулна. 5 удаагийн сургалтад архины хамааралтай 50 иргэнийг хамруулна. 7 өрхийг архины хамаарлаас гаргана. | “Хүчирхийлэлгүй аймаг зорилтын хүрээнд 4 удаагийн сургалт 4 нөлөөллийн ажил, 2 удаагийн уралдааныг зохион байгуулж 5875 хүүхэд болон насан хүрэгчид хамрагдсан. Цахим сүлжээгээр 255 удаа мэдээлж нийт хандалт: 30600 байна. Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль 75 удаагийн сургалтад давхардсан тоогоор 10698 иргэн хамрагдлаа. Байгууллагын дэргэд “Охид, хөвгүүдийн зөвлөл”-ийг ахлах ангийн 24 охид, 11 хөвгүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулан уулзалтаа зохион байгуулан зөвлөлийн дүрмийг батлаад байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх “Охид, хөвгүүдийн өрөө”-г түшиглэн охид, хөвгүүдийн клубыг 120 сурагчид “Бэлгийн боловсрол”, “Гэр бүл төлөвлөлт” сэдвээр сургалт зохион байгуулсан. “Гэр бүлийн эрүүл мэндийн боловсрол” ТББ-тай хамтран “Өсвөр насны хүүхдийн жирэмслэлт”, “Гэр бүл төлөвлөлт”, “Нөхөн үржихүй” сэдэвт сургалтыг 8 ЕБСургуулийн 620 охидод сургалт зохион байгуулсан. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 280 өрхийн судалгааг гаргаж архины хамааралтай 6, нэн ядуу 9, өрх толгойлсон 8, хүчирхийллийн харилцаатай 2 өрхүүдэд “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Санхүүгийн боловсрол” сэдэвт сургалт, Зан үйлийн өөрчлөлттэй 10 иргэнд “Аавын түшиг” 40 цагийн 10 модуль сургалт, албадан саатуулагдсан 53 иргэнд “Зан үйлд нөлөөлөх албадан сургалт” хөтөлбөрийн 10 модуль сургалтыг 13 удаа зохион байгуулж, сэтгэл зүйн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгсөн. 4 төрлийн 15 удаагийн сургалтад 88 иргэнийг хамруулж. 3 иргэнийг архины эмчилгээнд хамруулсан. | |
| 59 | 2.5.2 | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэг, мэдээллийг олгох ажлыг зохион байгуулна. | Улсын болон орон нутгийн төсөв | Ахлах ангийн сурагчдын дунд “Гэр бүл төлөвлөлт”, “Үерхэл нөхөрлөл” сэдэвт сургалтад хамрагсад Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдсан сурагчид | 2021 | 42 ахлах ангийн сурагч сургалтад хамрагдсан. | 650 сурагч хамруулна. Өсвөр насны нийт сурагчдын 10 хувийг хамруулна. | Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр 1 зөвлөл байгуулагдаж, 3 удаагийн сургалтад 1086 хүүхдүүд хамрагдан гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн.<br>Ерөнхий боловсролын 8 сургуулийн сэтгэл зүйчид сурагчдад сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэх ажлыг зохион байгуулж байна. | 70% |
| 148 | 4.1.11 | Төрийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа бодлго шийдвэр, ажил үйлчилгээний “Сэлэнгэ тойм” мэдээ мэдээллийн хөтөлбөртэй болж, цаасан суурьт болон цахим сэтгүүлээр дамжуулан сурталчилна. | 8.5 сая/ төг | Иргэд олон нийтийг мэдээллээр хангах | 2021 | 2000 ширхэг сэтгүүл | 4000 ширхэг сэтгүүл | Сэлэнгэ аймгийн 17 сум, 6 тосгон нийт ард иргэдэд хүрч байгаа орон нутгийн хэвлэл болох “Сэлэнгийн мэдээ” сонины дугаар бүрт “Сэлэнгэ тойм” тогтмол буланг ажиллуулж, төр захиргааны онцлох мэдээ мэдээллийг тоймлон хүргэх ажлыг гүйцэтгэлээ.<br>Сар тутмын мэдээллийн багцаар гардаг “Сэлэнгийн мэдээ” сонины 12 удаагийн дугаарт нийтдээ 120 гаруй удаагийн мэдээ мэдээлэл, ярилцлагыг бэлтгэн гаргаж, төр төсвийн байгууллагууд хэмнэлтийн горимд шилжсэн энэ хугацаанд төрийн ажил үйлчилгээний мэдээ мэдээлэл бүхий “Өргөн Сэлэнгэ” сэтгүүлийн 3 удаагийн дугаарыг 3000 ширхэгээр бэлтгэн гаргаж иргэд олон нийтэд сурталчлан ажиллалаа. | 70% |
| 149 | 4.1.12 | Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд бүх нийтийн оролцоо, мэргэжлийн | Орон нутгийн төсөв | ГУС арга хэмжээний хүрээнд хийсэн сургалтын тоо, Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хийсэн хяналт, шалгалтын тоо, | 2021 | ГУС арга хэмжээний хүрээнд хийсэн сургалт-180<br>Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хийсэн хяналт, шалгалт -10<br>Сэрэмжлүүлэг | Мэргэжлийн ангийн алба хаагчдын мэдлэг ур чадвар дээшилж, сум орон нутаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн эрсдэл эмзэг байдал | Аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль”-ийг 2022 оны 6 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулж “Дүүрэн онц” үнэлгээтэй дүгнэгдсэн. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газар, нийслэлийн Онцгой байдлын газар, Монголын Улаан загалмай нийгэмлэг зэрэг байгууллагуудаас | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгууллагын бэлэн байдлыг ханган, гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлж, шаардлагатай сумдад онцгой байдлын тасаг нэгжийг байгуулна. | | Сэрэмжлүүлэг мэдээ, мэдээлэл, зөвлөлмж түгээсэн тоо | | мэдээ, мэдээлэл, зөвлөлмж түгээсэн тоо-1640 | буурна. | бүрдсэн 5 ажлын хэсгүүдийг байгуулан өргөн хүрээтэйгээр Сэлэнгэ аймгийн 17 сум, 6 тосгоны нийт **8742** иргэдийг хамруулсан.<br>Гамшгаас урьдчилан сэргийлэх 23 нэгдсэн арга хэмжээг ДЗМОУБ, Улаан загалмайн хороо болон бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулж 87383 хүнд сэрэмжлүүлэг санамж материал тарааж ажилласан. Иргэдэд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг хүргэх зорилгоор “Онцгой байдлын цаг” нэвтрүүлгийн 14 удаагийн дугаарыг бэлтгэж Онцгой байдлын газрын болон 17 сумын албан ёсны цахим хуудсанд байршуулж ажилласан. Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах анги, салбарууд автомашин техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдал, гамшигтай тэмцэх багаж хэрэгсэлд 89 удаа үзлэг шалгалт зохион байгуулж нийт 132 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийж гүйцэтгэсэн. Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах анги, салбарууд тактикын сургууль 21 удаа зохион байгуулж давхартсан тоогоор 2218 алба хаагч, тархалтын сургуулийг 227 удаа зохион байгуулж давхартсан тоогоор 2415 алба хаагчийг тус тус хамруулан гал унтраах тактикийн дадлага сургуулийг зохион явууллаа.<br>Цагааннуур суманд эрэн хайх, аврах салбар, Баянгол суманд эрэн хайх, аврах бүлэг байгуулахад шаардагдах төсөв, барилга, газрын асуудлыг сум орон нутгаар шийдвэрлүүлж, эрэн хайх, аврах бүлэг, салбарын байгуулахад шаардагдах норм | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | стандарт дагуу саналын төслийг боловсруулж Онцгой байдлын ерөнхий газар болон холбогдох дээд шатны байгууллагад санал хүргүүлсэн боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсөв, орон тоог нэмэгдүүлэх боломжгүй тухай хариу ирүүлсэн тул 2023 оны төлөвлөгөөнд дахин тусгахаар төслийг хүргүүлсэн. Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын Гал, гамшгийн удирдах газар, Ази, Африкийн хөгжлийн тусламжийн сан зэрэг байгууллагуудтай хамтран Шаамар, Цагааннуур, Хүдэр, Түшиг сумдын гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, сайн дурын албадад буцалтгүй тусламжаар гал унтраах зориулалтын 4 автомашиныг шийдвэрлүүлсэн. Тус авто машиныг ашиглах сумдын холбогдох албан хаагч нарыг сургалтад хамруулах, дээрх автомашинуудыг нэмэгдсэн өртгийн албан татвар болон холбогдох бусад хураамжаас чөлөөлүүлэх, хүлээн авахад шаардагдах 200.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр шийдвэрлүүлж автомашинуудыг сумдад хүлээлгэн өгсөн. | |
| 150 | 4.1.13 | Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг зөвлөн туслах үйлчилгээ, сургалт, тандалт, хяналт шинжилгээний арга хэлбэртэй хослуулах, эрсдэлийн судалгаа, баазыг | Батлагдсан төсвийн хүрээнд | Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн тоо | 2021 | 2021 онд нийт 5368 объектод эрсдэлийн үнэлгээ хийж иргэд аж ахуй нэгжүүдэд Шилэн хяналтын цахим системээр дамжуулан зарласан. | Үйл ажиллагаа стандартын шаардлагад нийцсэн байна | 2022 оны жилийн эцсийн байдлаар 130 аж ахуйн нэгж байгууллагад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн бөгөөд үүнийг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 29 объектоор өссөн дүнтэй байна. Зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан объектуудад дунджаар хууль сахин мөрдөлт 71.3 хувьтай, эрсдэл үүсэх магадлал 28.7 хувьтай, 2 объект их эрсдэлтэй, 16 объект | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлнэ. | | | | | | дунд эрсдэлтэй 31 объект бага эрсдэлтэй үнэлэгдсэн байна. Зөвлөн туслах үйлчилгээний явцад зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор 222 заалттай 11 зөвлөмжийг өгч биелэлтийг тооцоход 87.5 хувь хангагдсан үзүүлэлттэй байна. | |
| **4.2 Хууль, эрх зүй** | | | | | | | | | |
| **Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх замаар иргэн бүр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэг төлөвшлийг бий болгож, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журмыг хангах ажлыг дээшлүүлж, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.** | | | | | | | | | |
| 151 | 4.2.1 | "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангах бодлого"-ыг боловсруулан хэрэгжүүлнэ. | Аймаг, орон нутгийн төсөв | Бодлогын баримт бичгийн тоо Зохион байгуулагдсан Команд штабын сургуулийн тоо, | 2021 | Салбарын хуулиар хүлээсэн эрх үүргийн судалгааг гаргаж, баримт бичгийн төслийг боловсруулж, батлуулсан. | Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлсэн байна | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн зөвлөмж чиглэлийн дагуу Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах аймгийн бодлогыг 5 бүлэг 10 бүрэлдэхүүн хэсгийн 67 арга хэмжээтэйгээр боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 111 дүгээр тогтоолоор батлуулж, сум, агентлагуудад хүргүүлэн 2022 оны хагас, бүтэн жилийн тайланг нэгтгэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлсэн. | 100% |
| 152 | 4.2.2 | Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай хүргэн иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ. | Орон нутгийн төсөв | Аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь, Хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон захиргааны акт, хуулиар эрх олгосон этгээдийн гаргасан эрх зүйн үр дагавар бүхий шийдвэрийн тоо | 2021 | Иргэд эрх зүйн анхан шатны мэдлэг, мэдээлэл нэмэгдсэн. | Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамжийг хуульд нийцүүлэн батлуулж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхэд | Аймгийн Засаг даргын захирамжаар жил бүр захиргааны шийдвэр хянах, хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах төлөвлөгөө, хуваарийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.<br>2021-2022 онд 62161 иргэд, төрийн албан хаагчдад хууль, эрх зүйн албан болон албан бус сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулсан.<br>Аймгийн Засаг даргын захирамжаар “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ой”-г | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн байна, Сар бүр 1-ээс доошгүй удаа, жилд 12 удаа эорх зүйн хөтөч нарыг давтан сургалтанд хамруулж, сургалт, сурталчилгааны ажлыг нэмэгдүүлсэн байн | тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд сургалт, сурталчилгааны ажлыг хийж, Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг иргэд олон нийтэд сурталчилсан.<br>Мөн шинээр хэрэгжиж эхэлсэн хуулиудаар Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран 3 удаагийн цахим сургалт зохион байгуулж 110 төрийн албан хаагч хамрагдсан.<br>“Хуулийн өдөр” арга хэмжээг Хараа болон Ерөө бүсэд “Архив албан хэрэг хөтлөлт”, “Авлигын хор хөнөөл”, “Төрийн албаны тухай хууль”, “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж 150 албан хаагчийг хамруулсан. “Глоб интернэйшнл төв” төрийн бус байгууллагатай хамтран “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтийг болон төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх мониторинг хийх зорилгоор “Миний мэдэх эрх” сургалт зохион байгуулж сургалтад төрийн албан хаагчид, иргэний нийгмийн төлөөлөл, сэтгүүлч хэвлэл мэдээллийн төлөөллийг хамруулсан. | |
| 153 | 4.2.3 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана. | Аймаг, орон нутгийн төсөв | Хамрагдсан аж ахуйн нэгж, иргэдийн тоо | 2021 | 14 аж ахуйн нэгж байгууллагын 290 иргэн | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг аймгийн хэмжээнд төлөвлөгөө гарган зохион байгуулсан байна, Гэмт хэргийн гаралт өмнөх оны мөн | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Хөтөлбөр батлах тухай” 96 дугаар тогтоолоор батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөр”-ийн 1 дүгээр үе шатыг хэрэгжүүлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн хангалттай үнэлэгдсэн.<br>Сүхбаатар, Алтанбулаг сумдын гудамж, зам, талбайг теле хяналтын | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үеэс 3 хүртэл хувиар бууруулсан байна | системийг өргөтгөх төслийн хүрээнд Сүхбаатар, Алтанбулаг сумыг теле хяналтын нэгдсэн системд холбох, тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуй нэгжийг уг системд холбох ажлыг үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөсөн. Төслийн хүрээнд орон нутгийн хөрөнгөөр 40 цэгт 100 камер байршуулахад 244,000,000 /хоёр зуун дөчин дөрвөн сая/ төгрөгийн зардлын төсвийг гаргаж шийдвэрлүүлсэн. Сумдын цагдаагийн хэсгүүдийг теле хяналтын камерын системд холбох ажлын хүрээнд Орхон, Орхонтуул, Баруунбүрэн сумдын Цагдаагийн хэсгийн байруудыг камержуулахад нийт 35,5 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлэсэн. | |
| 154 | 4.2.4 | Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нийтэд түгээн авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх хандлагыг төлөвлшүүлнэ. | Орон нутгийн төсөв | Аймгийн шудагра байдлын үнэлгээний индекс | 2021 | 70 орчим контентуудыг 22 агентлаг, 17 сум, 6 тосгодод иргэд, олон нийтэд хүргэн, нийт 889 иргэнд 1000 гаруй тараах материалыг олгон соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан. | Авлигын эсрэг анхан болон давтан сургалтад 2021 онд шинээр болон дэвшин томилогдсон 128 албан хаагчийг хамруулсан. Аймгийн шударга байдлын үнэлгээ 2021 онд 76,3 оноогоор үнэлэгдсэн. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, 95.7 хувийн үнэлгээтэйгээр тайлагнаж, Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулах, төсөлд олон нийт, сонирхогч бүлгийн санал, хүсэлтийг авах болон иргэд, аж ахуй нэгжээс санал, өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах боломжийг бүрдүүлэх, эрх бүхий байгууллагаас олгож буй тусгай зөвшөөрөл, түүний талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуй нэгжийн жагсаалт, үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамж, үнэ тарифын талаарх мэдээллийн хууль эрх зүйн үндэслэл | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | журмын хамт байршуулах, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг олон нийтэд мэдээлэх, мэдээллийн баяжилт болон тасралтгүй ажиллагааг хангаж тухай бүр шуурхай байршуулж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллахыг “Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай” захирамжаар сум, агентлагийн удирдлагуудад үүрэг, чиглэл өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан. Авлигатай тэмцэх газартай хамтран “Таны эрх, таны оролцоо-авлигад үгүй гэж хэлье” соён гэгээрүүлэх өдөрлөгийг зохион байгуулж, өдөрлөгт 24 агентлагийн 90 төрийн албан хаагч 8 багийн 140 иргэн, 6 сургуулийн 287 сурагчдыг хамруулсан.<br>Авлигатай тэмцэх газраас “Гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах тухай”, болон “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар” ирүүлсэн нийт 14 мэдэгдэл, албан тоотын дагуу аймгийн Засаг даргын 2022 оны “Зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай” 01/905 дугаартай албан тоот, Авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2022 оны “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 01/1196, 01/1197 дугаартай албан тоотуудыг тус тус гарган сумд, агентлагуудад хүргүүлж, үр дүнг тооцон ажиллаж байна. | |
| 155 | 4.2.5 | Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгож, иргэн бүрийн аюулгүй | Улсын болон орон нутгийн | Хэрэгжилтийн хувь | 2021 | 83.1 | 84.2 | Хүний эрхийн Үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл хамтран “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг бэхжүүлэх нь” | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байдлаа хангах мэдлэг мэдээллийг нийтэд түгээн хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | төсөв | | | | | төслийн хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр сумдын Засаг дарга, тосгодын захирагч нарт “Жендэр ба хүний эрх” сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтад 60 албан тушаалтныг хамруулан ажилласан. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2012-2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 2023-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах санал, 2018-2022 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, түүний хүрээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний талаарх мэдээллийг аймгийн хэмжээнд нэгтгэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн.<br>Хүний Эрхийн Үндэсний Комиссын орон нутаг дахь ахлах шинжээчтэй хамтран Баруунбүрэн, Сант, Орхон, Орхонтуул, Шаамар, Алтанбулаг сумдад Хүний эрхийн сургалт зохион байгуулах төлөвлөгөөг гарган батлуулж, сургалт, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, 170 гаруй иргэд, төрийн албан хаагчийг хамруулан ажилласан.<br>Хүний Эрхийн Үндэсний Комиссоос ирүүлсэн шаардлагын дагуу Сүхбаатар сумын “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захиралд холбогдолтой шаардлагад дурьдагдсан хөдөлмөрийн харилцаан дахь ялгаварлан гадуурхалт, ажлын | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байрны дарамтаас ангид байх эрх зөрчигдөхөд нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгуулах, Сант сумын төрийн албан хаагчдын гомдлын мөрөөр ажиллаж, холбогдох хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулан ажилласан. | |
| 156 | 4.2.6 | Стандарт шаардлагад нийцсэн төрийн архивын барилга барих ажлыг үе шаттай шийдвэрлэнэ. | Улсын төсөв | Тоо | 2021 | 0 | 1 | Зураг төсвийн “ОСИБ ЗТ” ХХК-тай хамтран архивын барилгын зураг, төсвийн төслийг боловсруулан ХЗДХЯаманд хүргүүлсэн.<br>Төрийн архивын барилгын эх загвар зургийг аймгийн ерөнхий архитектороор батлуулж, зураг төсвийн “ОСИБ ЗТ” ХХК-иар Архивын барилгын угсралтын ажлын төсвийг хийлгүүлэхээр шийдвэрлэж, 2023 оны төсөвт зардлыг тусгаж оруулсан. | 70% |
| 157 | 4.2.7 | “Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн улсын бүртгэлийн мэдээллийг цахимаар авах боломж нөхцлийг сумдад бүрдүүлнэ. | Улс, орон нутгийн төсөв | нэмэгдсэн цахим үйлчилгээний тоо | 2021 | Цахимд сумдыг холбосон. | 4 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан Улсын бүртгэлийн ерөнхий газраас 22 төрлийн лавлагаа, 50 төрлийн үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд үүнээс аймгийн хэмжээнд Улсын бүртгэлийн хэлтсээс иргэний бүртгэлийн 26 төрлийн үйлчилгээ, 12 төрлийн лавлагаа, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 13 төрлийн үйлчилгээ, 7 төрлийн лавлагаа, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 9 төрлийн үйлчилгээ, 3 төрлийн лавлагааг тус тус цахимаар үзүүлж байна.<br>Эдгээрээс 27 үйлчилгээ нь шуудан хүргэлтээр хийгдэж, цаашид цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, шинээр 50 төрлийн үйлчилгээ болон 38 шуудан хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлэхээр ажиллаж байна.<br>Улсын бүртгэлийн ерөнхий газраас | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | олгосон “Бүртгэлийн Киоск” төхөөрөмжийг Алтанбулаг боомтод байршуулж, Хаан банктай хамтран ажиллах гэрээний дагуу Мандал, Сайхан сумд болон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний байранд Хаан банкнаас нэгж бүр нь 30.0 сая төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг киоск машиныг бүртгэлийн байгууллагад зориулан хөгжүүлэлт хийн суурилуулж иргэдэд үйлчилж байна.<br>Мөн Сүхбаатар, Алтанбулаг, Мандал, Сайхан сумд болон лавлагаа үйлчилгээний улсын бүртгэгч нарт пост төхөөрөмжийг 5 ширхэгийг байршуулсан. | |
| 158 | 4.2.8 | Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг шинэчилж хил хамгаалах албыг бэхжүүлэн, хил хамгаалах байгууллагуудын нэг цонхны үйлчилгээний байрыг ашиглалтад оруулна. | Улс, орон нутгийн төсөв | үзүүлсэн дэмжлэгийн тоо | 2021 | Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, албаны бэлэн байдлыг хангахад аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс дэмжлэг үзүүлсэн. | 100% | Хилийн 0284 дүгээр салбар Хар горхийн хилийн заставт 6 айлын нэгдсэн халаалттай байр барьж 2021 оны 07 дугаар сард ашиглалтад оруулсан.<br>Монгол Улсын хилийн тухай хуулийн 39.4 дэх хэсэгт заасны дагуу офицер ахлагч нарын 18 гэр бүлийг ажлын байраар хангаж, 1 ахмад хилчинг ажлын байранд зуучилж, алба хаагчдад 10 айлын орон сууц барих “Хилчин хотхон”-ны газрын асуудлаар аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт газар авах хүсэлтээ хүргүүлж, 10 алба хаагчдид өрхийн зориулалттай 0.7 га газрыг өмчлөх эрхийг шийдвэрлэсэн.<br>Монгол Улсын Хилийн тухай хуулийн дагуу “Хилийн бүсийн өргөнийг шинэчлэн тогтоох тухай” 2021 оны Хил хамгаалах ерөнхий газрын дарга, аймгийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжаар улсын хилийн бүсийн өргөн, түүний зааг, эргэлтийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | цэгүүдийг шинэчлэн баталсан.<br>Хил хамгаалах ерөнхий газар, Хилийн цэргийн 0119 дүгээр ангиас Хилийн 0243 дугаар ангийн цэргийн байр, эмнэлгийн барилга барих газрын хэмжилтийг хийж, барилгын суурийг цутган ажлыг эхлүүлсэн. Барилгын ажил 2022 оны улсын төсвийн 1,115 сая төгрөгөөр баригдах ба 2023 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.<br>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Сүхбаатар төмөр замын боомтод баригдсан хил хяналтын байгууллагуудын “Нэг цэгийн үйлчилгээний” 6 давхар цогцолборын барилгын ажил 2022 оны 4 дүгээр улиралд ашиглалтад оруулсан. | |
| 159 | 4.2.9 | Хууль хяналтын байгууллагуудын салбар дундын хамтын ажиллагааг сайжруулна. | Орон нутгийн төсөв | Зохион байгуулсан уулзалтын тоо | 2021 | 2 | 5 | Шүүхийн шинжилгээний албанд томилогдон ирсэн алба хаагчдыг орон сууцжуулах зорилгоор төвийн дулаан, цэвэр бохирт холбогдсон байгууллагын байранд 11 албан хаагчтай түрээсийн гэрээ байгуулан, тав тухтай амьдрах боломжоор хангасан.<br>Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хамтран хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа, албадлагын арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхээр хамтарсан төлөвлөгөө гарган ажилласан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 200.0 сая төгрөгийн өртөг бүхий Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн 170м2 талбай бүхий 6 ажлын өрөө, автомашины граж бүхий барилгыг “Сэлэнгэ таван хан” ХХК-иар гүйцэтгүүлж байгаа бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар барилгын гүйцэтгэл 70 хувьтай байна. Хууль | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлсэн “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд “Түр хамгаалах байр”-ны барилгыг 198.4 сая төгрөгөөр үнэлэн үндсэн хөрөнгөнд бүртгэн, үйл ажиллагааг эхлүүлсэн. Түр хамгаалах байрыг орон нутгийн 105.0 сая төгрөгийн төсвөөр дээвэр, сангийн ажлыг засварлан сайжруулаад байна. | |
| **4.3. Батлан хамгаалах** | | | | | | | | | |
| **Орон нутгийн хамгаалалтын тогтолцоо бэхжиж, батлан хамгаалах чадавх дээшилсэн байна.** | | | | | | | | | |
| 160 | 4.3.1. | Цэргийн насны залуучуудыг алба хаах хүсэл сонирхолыг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. | Орон нутгийн төсөв | Цэргийн насны залуучуудад цэргийн алба хаах хүсэл сонирхол төрүүлэх комент, сурталчилгааны ажил зохион байгуулах, “Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх | 2021 | “Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, боловсролын түвшинг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийг 2020 онд хэрэгжүүлэн дуусч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн VII хуралдаанаар илтгэн хэлэлцүүлж хөтөлбөрийн тайланг “хангалттай” гэж дүгнэсэн. | Аймгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран цэргийн насны залуучуудад чиглэсэн суртал ухуулагын ажлыг зохион байгуулж алба хаах хүсэл сонирхолыг төрүүлсэн байна. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийг эрүүл мэндийн газар, сумдын эрүүл мэндийн төвүүдтэй хамтран хийж аливаа өвчин эмгэгээс өөрийгөө сэргийлж чаддаг болно. | “Цэргийн насны залуучууд болон идэрчүүдийн эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл иргэн байхын ач холбогдлыг таниулах, эх оронч үндэсний үзэл төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ” гэсэн зорилгын хүрээнд бүх сумaнд "Эрүүл иргэн энхийн манаа" сургалтыг 12 дугаар сарын 01-15-ны өдрүүдэд зохион байгуулж, нэгдсэн дүнгээр ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 850 гаруй сурагчид, цэргийн насны 470 гаруй залуучууд нийт 1320 иргэд хамрагдсан. “Монгол хүн байхын учир”, “Эрүүл иргэн байхын ач тус” нөлөөллийн лекц, “Идэвхтэй хөдөлгөөн–Эрүүл мэнд” сэдвийн хүрээнд сургалтад хамрагдагсдад цэргийн 1 болон 2 дугаар 16 тоот дасгалыг заах, сургасан бол иргэн – цэргийн харилцааг бэхжүүлэх, Монгол Улсын Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнийг сурталчлах ажлын хүрээнд “Эх оронч үзэл үндэсний бахархал – Монгол цэрэг- Дэлхийн цэрэг” сэдвээр | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | илтгэл тавьж, харилцан ярилцаж, арга хэмжээний үеэр “Өнө мөнх дурсагдах алдар-Бидний бахархал” сэдвийн хүрээнд сумаас төрөн гарсан партизан цэргүүд, БНМАУ-ын Баатар, хөдөлмөрийн баатрууд болон гавъяат цолтнууд, алдартнуудын ажил, амьдрал, намтарын талаар сурталчлах арга хэмжээг зохион байгуулсан. | |
| 161 | 4.3.2. | Цэргийн штабын сургалтын төвийн байгуулна. | Орон нутгийн төсөв | ЦШ-ын төлөвлөгдсөн сургалт, дадлага хийгдэх, төрийн захиргааны албан хаагчдыг "Цэргийн бэлтгэл" сургалт явуулах орчин бүрдсэн байх | 2021 | Зүүнбүрэн 000006037 | Сургалтын төвийн ерөнхий зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, хашааны суурин бетон цутгах ажлыг эхлүүлнэ. | Зүүнбүрэн суманд Цэргийн штабын сургалтын төвийн барилгыг барихаар 5 га газрын гэрчилгээг шинээр авч, сургалтын төвийн хашааны суурийн ажлын нүхийг ухаж цутгалт хийхэд бэлэн болгосон. 2023 оны төсөвт 120 сая төгрөгийг тусгуулан ажиллаж байна<br><br>. | 70% |
| 162 | 4.3.3. | Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, "Дөл" тэмцээнийг зохион байгуулна. | Орон нутгийн төсөв | Үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг үе шаттай зохион байгуулах /17 сумын хэмжээнд/ | 2021 | Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургууль, МСҮТ-ийн сурагчидын дунд зохион байгуулсан. | Алтанбулаг, Шаамар, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад лекц уншиж Монгол эх орон, түүх уламжлал, зан заншлаараа бахархах, эх орноо хайрлахын үнэ цэнийг ойлгуулсан байна. | Аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл-2022” цогцолбор тэмцээнийг аймаг, бүс, сум гэсэн 3 үе шаттайгаар зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 1700 гаруй сурагчид, 130 гаруй багш, ажилчид, 200 гаруй төрийн албан хаагчид, 3400 гаруй эцэг эхчүүд оролцсон.<br>Аймгийн Засаг даргын 2022 оны А/123 дугаар захирамжаар батлагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан Батлан хамгаалахын сайдын нэрэмжит улсын аварга шалгаруулах “Дөл-2022” цэрэг-спортын цогцолбор тэмцээнд Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сургуулийн “Сүлд” тасаг амжилттай оролцож, цогцолбор тэмцээний нэг төрөл болох ханын сонины уралдаанд “Тэргүүн байр”-т Сэлэнгэ аймгийн “Сүлд” тасгийн сурагч А.Мөнхтөр, Мишээл нар тэргүүлсэн. Сэлэнгэ аймгийн "Сүлд" тасгийн захирагч Б.Тэмүүжин ҮБХИС-д суралцах урилгаар шагнуулсан ба соёлтой цэвэрч нямбай тасгаар шалгарсан. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолоор баталсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”, хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий Командлагчийн санаачилгаар "Бидний бахархал" төслийн нээлтийн арга хэмжээг Ардын хувьсгалын өлгий нутаг Сэлэнгэ аймагт "Монгол хурандаа” нийгэмлэгээс анх удаагаа 2022 оны 12 дугаар сарын 05-09-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагуудын 500 гаруй алба хаагчид, ерөнхий боловсролын сургуулийн 1800 гаруй оюутан, сурагчид хамрагдаж, хүүхэд, залуучуудад цэрэг эх орон үндэсний үзэл төлөвших, эх орноо хайрлан хамгаалахын ач холбогдлыг ойлгуулсан сургалт болсон. | |
| 163 | 4.3.4. | Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, бүх нийтийн оролцоотойгоор | Орон нутгийн төсөв | Томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй төлөвлөгдсөн сургалт, дадлагыг үе шаттай зохион байгуулах | 2021 | 17 сумдын “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-г боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулсан. | Томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж иргэдэд орон нутгийн хамгаалалтын | Аймгийн Засаг даргын 2022 оны А/03 тоот захирамжийн дагуу "Цэргийн бүртгэл" сургалтыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга болон Багийн Засаг дарга нар, Бугант, Дулаанхан, Номгон, Түнхэл, Хэрх тосгоны хууль эрх зүйн мэргэжилтэн болон Сүхбаатар сумын багийн нийгмийн ажилтнуудад “Цэргийн бүртгэл явуулах журам” | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, хамгаалах олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | | | | тухай хууль болон бусад холбогдолтой чиглэлээр ойлголт өгнө. | сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулж, орон нутгийн хамгаалалтыг хэрхэн зохион байгуулах, томилгоот нэгжийг томилгоожуулах, материал хэрэгслээр хангах, техник хэрэгслийг даалгаваржуулах, бэлэн байдлыг хангах, орон нутгийн хамгаалалтын нөөц бүрдүүлэх тодорхой хэмжээний ойлголттой болсон ба иргэдэд хууль сурталчлан таниулах, дадлага, чадварыг нэмэгдүүлсэн.<br>Батлан хамгаалахын сайдын 2022 оны 1а/2525 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/290 дүгээр захирамж, Цэргийн штабын 2022 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Төвийн бүсийн аймгуудын сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар Булган аймагт “Цэргийн бэлтгэл” сургалтад 2022 оны 08 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд хамрагдсан. Булган сумын Батлан хамгаалах товчоог дэлгэн томилгоот бүрэлдэхүүний хээрийн нөхцөлд байрлах байр, техник болон хөтлөгдөх баримт бичгийг дэлгэн үзүүлэх сургуулилтыг зохион байгуулсан.<br>Мөн энэ үеэр Батлан хамгаалах сайдын 2020 оны А/121 дүгээр тушаалыг үндэслэн буудлага хийх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж хүн нэг бүрээр гарын үсэг зуруулан баталгаажуулж аюулгүй байдлыг хангуулан “Буудлагын анхны дасгал”-ыг Булган сумын Өндөр хөтөлийн районд урьдчилан бэлтгэсэн буудлагын талбайд буудлага явуулснаар сумдад Батлан хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах мэдлэг, чадварыг дээшлүүлсэн. | |

| ТАВ. НОГООН ХӨГЖИЛ | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Байгалийн унаган төрхийг хадгалж, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглан, байгальд ээлтэй үзэл санааг түгээн дэлгэрүүлнэ.** | | | | | | | | | |
| 164 | 5.1.1 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжих, мэдлэг, олгоно. | - | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжих мэдлэг олгох ажил, арга хэмжээ зохион байгуулсан эсэх | 2021 | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжих мэдлэг олгох ажил, арга хэмжээ зохион байгуулсан. | Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжих мэдлэг олгох ажил, арга хэмжээ зохион байгуулна. | “Дэлхийн зөн” олон улсын байгууллагатай хамтран 2 удаа цахим сургалт зохион байгуулж Ерөнхий боловсролын 24 сургуулийн 80 гаруй сурагчдыг хамруулж, ногоон хөгжил, ногоон үзэл санааг төлөвшүүлэх зөвлөмж бүхий гарын авлага материалыг, 24 сургагч багш нарт 4 багц номыг олгосон. Боловсрол, шинжлэх ухааны газартай хамтран "Ус бидний амьдралд", “Дэлхийн усны өдөрт”, “Дэлхийн усны нөөц” шторкуудыг 35 сургуулийн 17210 сурагчдад хүргэж сурталчиллаа. “Тогтвортой хөгжлийн боловсрол хэрэглээ”, “Тогтвортой хөгжлийн төлөө”, “Нүүрстөрөгчийн ул мөрийг тооцох, багасгах”, “Цахилгааны хэрэглээг багасгах”, "Хуванцар савны хэрэглээг багасгая", “Хөрсний бохирдол”, “Ногоон ирээдүй, “Бидний ирээдүй”, “Хогоо ангилан ялгаж сурцгаая”, “Гялгар уутнаас татгалзая”, “Уур амьсгалын өөрчлөлт”, “Цэцэрлэг, сургуулийн орчны үнэлгээ”, “Орон нутгийн төлөв байдал” сэдвүүдээр сурагч, багш, ажилчид, иргэд нийт давхардсан тоогоор 19 төрлийн 321,9 мянган хүнд сургалтыг танхим болон онлайнаар сургууль, цэцэрлэгүүд зохион байгуулж, шинээр 19 хүүхдэд ногоон паспортыг олгосон. | 100% |
| 165 | 5.1.2 | Сибирь жодоо, сибирь хуш, сибирь гацуур зэрэг ховор зүйлийн модлог ургамлыг тарималжуулах | 30.0 | Сибирь жодоо, сибирь хуш, сибирь гацуур зэрэг ховор зүйлийн үнэт модлог ургамал, байгалийн ховор, | 2021 | 2021 онд 1497 га талбайд 3,7 сая ширхэг мод, бут, сөөг, Сибирь жодоо, сибирь хуш, сибирь гацуур зэрэг | Хуш, жодоо, гацуурын үр бэлтгэх, тарьж, 3 га талбайд ховор модыг тарьж ургуулсан байна. | Сибирь хуш модны үрийг Хүдэр сумын Ойн анги 1.5 га талбайд, Ерөөгийн бүсийн сум дундын Ойн анги 5 га талбайд тус тус мод үржүүлгийн газрууддаа хуш модны 6100 ширхэг тарьцаар ойжуулалтын ажлыг хийсэн. Энэ онд 1497 га | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. | | ашигт ургамлыг тарималжуулсан талбайн хэмжээ | | ховор зүйлийн үнэт модлог ургамлаар таримлжуулсан. | | талбайд 3,7 сая ширхэг мод, бут, сөөг, Сибирь жодоо, сибирь хуш, сибирь гацуур зэрэг ховор зүйлийн үнэт модлог ургамлаар таримлжуулсан. | |
| 166 | 5.1.3 | “Ногоон сум” хөдөлгөөнийг өрнүүлнэ. | - | “Ногоон сум” аяныг өрнүүлсэн эсэх, “Ногоон сум” шалгаруулах удирдамжийг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулсан эсэх | 2021 | “Тохижилт, ногоон байгууламж аян”-ыг зохион байгуулж, “Шилдэг сум”, “Шилдэг баг”, “Шилдэг албан байгууллага”, “Шилдэг өрх”-ийн төрөлд 11 номинациар шалгаруулж, урамшуулж ажилласан. | "Нонгоон сум" аяныг эрчимжүүлэх "Ногоон сумыг шалгаруулж, тоо нэмэгдсэн байна. “Ногоон сум” шалгаруулах удирдамжийг ногоон хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулсан байна. | Аймгийн Засаг даргын 2022 оны “Тэрбум мод-Их ажлын эхлэл хөдөлгөөнийг орон нутаг зохион байгуулах”, “Бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулах” ажлыг 17 сум, 6 тосгонд хүргүүлж, мод тарьж ургуулах чиглэл, зөвлөмж өгч, аймгийн хэмжээнд 1745 өрх 23,2 мянган ширхэг модыг шинээр тарьж, 24 га талбайд ногоон байгууламж, 1087.8 га талбайд ойжуулалт, 30 га талбайд ногоон зурвас, 5 га талбайд цэцэрлэгжүүлэлтийн ажлыг хийж, 467 аж ахуйн нэгж, 7.4 мянган иргэд 778.9 мянган ширхэг нийт 1497 га талбайд 3,7 сая ширхэг модыг тарихад 849.0 сая төгрөгийг зарцуулж, 3,2 сая ширхэг тарьц суулгацыг зах зээлд нийлүүлж, шинээр 6 бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулж, ногоон байгууламжийн 2665 м2 талбайг зүлэгжүүлэн, 614 цэцгийн мандал байгуулсан.<br>Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд идэвхи санаачлагатай ажилласан 6 байгууллагыг тодруулан батламж олгосон. | 100% |
| 167 | 5.1.4 | Гэр хорооллын болон аялал жуулчлалын бүсэд “Био жорлон” арга хэмжээг зохион | - | Гэр хорооллын болон аялал жуулчлалын бүсэд “Био жорлон” арга | 2021 | “Био жорлон” суурилуулах айл өрх, аялал жуулчлалын газруудын | 3 ариун цэврийн байгууламж, 4 эко модон жорлон ашиглалтад оруулж,5000 | Дэлхийн зөн олон улсын байгууллага, “Мобиком корпораци” ХХК-тай хамтран Орхон сумын сургуулийн барилгад ариун цэврийн байгууламж, БШУЯ-ны захиалгаар түлхүүр | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулж, хөрсний бохирдлыг бууруулна. | | хэмжээг зохион байгуулж, хөрсний бохирдлыг бууруулах эсэх | | судалгааг гаргасан. | өрхийн нүхэн жорлонг халдваргүйжүүлсэн | гардуулах гэрээний нөхцөлтэй Цагааннуур, Баруунбүрэн сумдын сургуулийн дотуур байранд ариун цэврийн байгууламжийг ашиглалтад оруулж,<br>Аймгийн аялал жуулчлалын гол зам дагуу Сүхбаатар сумын ногоон байгууламж, Сүхбаатар хаалга, Шаамар сумын Ээж мод, Алтанбулаг сумын "Хоёр элс" орчимд 4 эко жорлон байрлуулах ажлыг "Чухаг арвис" ХХК гүйцэтгэсэн. Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох зорилгоор 17 сумын 6 тосгоны 5000 айл өрхийн нүхэн жорлонг ашигтай бичил биетний идэвхжүүлсэн био бэлдмэлээр халдваргүйжүүлсэн. | |
| 168 | 5.1.5 | Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлнэ. | 16.0 | Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, гудамж талбайн гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлсэн эсэх | 2021 | Сүхбаатар суманд 3 га талбайд "Ногоон төгөл" байгуулж, "Дэд бүтцийн Сэлэнгэ төсөл"-д Сүхбаатар, Мандал, Сайхан сумдын алслагдсан багийн гэр хорооллын гудамж, зам, талбайн 1300 ширхэг шон бүхий орчин үеийн гэрэлтүүлгийн ашиглалтад оруулсан. | Аймгийн ногоон байгууламжийн хэмжээг 2665 м2 талбайгаар нэмэгдүүлж, 5 сумын гудамж талбайн гэрэлтүүлэг, 5 суманд камерыг суурилуулсан байна. | Аймгийн хэмжээнд 17 сумын 161 аж ахуйн нэгж, байгууллага, 6172 иргэн 56240 ширхэг мод, бут, сөөг, ойн сангийн 1497 га талбайд 3,7 сая ширхэг мод тарьж, шинээр 6 бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулж, ногоон байгууламжийн 2665 м2 талбайг зүлэгжүүлэн, 614 цэцгийн мандал байгуулан төв, суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Ерөө, Мандал, Сайхан, Жавхлант, Сүхбаатар сумын 2, 3-р багт 1 тэрбум 256 сая төгрөгийн гудамж, талбайн гэрэлтүүлгийг ашиглалтад оруулсан. Сүхбаатар сумын 7-р багийн нутаг дэвсгэрийн гудамж талбайг камержуулах ажлыг 79.4 сая төгрөг, Мандал суманд "Шуурхай удирдлагын жишиг төв"-ын телехяналтын камерыг 244.2 сая төгрөг, Сайхан сумын гудамж талбайн камержуулалтын ажлыг 25.0 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сая төгрөг, Шаамар сумын Дулаанхаан тосгоны 4 замын уулзвар, Шаамар сумын уулзвар, Алтанбулаг сумаас Сүхбаатар сум руу явах чиглэлийн замд орчны болон 100 км/ц хүртэлх тээврийн хэрэгслийн жолооч, автомашины дугаарыг тодотгох иж бүрэн камерыг суурилуулсан. | |
| 169 | 5.1.6 | Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлж, зөв дадалд сургана. | Орон нутгийн төсөв | Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар зохион байнуулсан арга хэмжээ | 2021 | Агаар бохирдлын эх үүсвэр улсын нэгдсэн тооллогыг зохион байгуулсан. | Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршигийн талаарх surталчилгааны ажилыг орон нутгийн ТВ, сонин, цахим хуудсанд байршуулж ажиллана. | Аймгийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2022 оны А/481 тоот захирамжаар байгуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 тушаал “Агаар бохирдлын эх үүсвэр улсын нэгдсэн тоо бүртгэл хийх журам”, “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл хийх заавар”-ын дагуу хийж, орчны бохирдлын эх үүсвэр, хаягдлын тооллого бүртгэлийн мэдээг https://envpol.mne.gov.mn/ цахим мэдээллийн санд 2023 оны 03 дугаар сарын 01-ний дотор бүртгэн тайлагнахаар ажиллаж байна. Аймгийн хэмжээнд агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллого хийх ажлын хүрээнд “Орчны бохирдлын эх үүсвэр, хог хаягдлын тооллогын мэдээллийн сан сэдэвт сургалт”-ыг аймгийн 17 сум, 6 тосгоны аж ахуйн нэгж, байгууллагын 73 иргэнийг хамруулсан. Агаарын бохирдлын хор уршиг, сөрөг нөлөөлөл талаарх сурталчилгааны видео контентийг аймаг болон сумдын цахим хуудсанд байршуулан сурталчилж байна. | 100% |
| **Нийт дүн** | | | | | | | | | **91.5%** |